

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР, 2007 ОНД

Улаанбаатар хот

2008 он

Танилцуулгыг хянан, боловсруулсан:

ҮСХ-ны дэд дарга Г.Гэрэлт-Од
МЭЗСГ-ын дарга Б.Бадамцэцэг
МЭЗСГ-ын ЭЗСХ-ийн дарга Ч.Даваасүрэн

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

МЭЗСГ-ын ЭЗСХ-ийн ахлах мэргэжилтэн М.Оюунжаргал
МЭЗСГ-ын ЭЗСХ-ийн мэргэжилтэн М. Оюун

Танилцуулгыг хэвлэлд бэлтгэсэн:

ТЗУГ-ын Мэдээллээр үйлчлэх төвийн ажилтан
Ж.Нямдаваа
Д. Батжав
М.Гантөгс

Танилцуулгыг ҮСХ-ны Мэдээллээр үйлчлэх төвд хэвлэв.

Хаяг: Засгийн газрын III байр, Улаанбаатар-20а, Монгол Улс

Утас: 322424

Имэйл: nso@magicnet.mn, Веб хаяг: <http://nso.mn>

АГУУЛГА

ОРШИЛ

I. Мал аж ахуй

I.1 Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт	7
I.2 2007 оны мал тооллогын дүн	11
I.2.1 Малтай болон малчин өрх, малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөл	11
I.2.2 Мал, тэжээвэр амьтдын тоо, бүтэц	13
I.2.3 Эрчимжсэн мал аж ахуй	24
I.2.4 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	26
I.2.5 Тэжээвэр амьтад	28
I.2.6 Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл	28
I.2.7 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	29
I.3 Мал эмнэлгийн үйлчилгээ	30

II. Газар тариалан

II.1 Тариалсан талбай	31
II.2 Хураасан ургац	33
II.3 Га-гийн ургац	37
II.4 Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	38

III. Мал бүхий өрхийн нэг удаагийн түүвэр судалгааны дүн	39
--	----

ДҮГНЭЛТ ХАВСРАЛТУУД

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтийн хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25
Азарга - 12-15
Бух - 35-45
Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс –	0.45
Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25
Гар тэжээл, хужир шүү -	1.0
Төмс ногооны хаягдал -	0.22
Үр тарианы хаягдал -	0.9
Лай -	0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно.

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүсэд:

Баруун бүсийн аймгууд – Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс – Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

Зүүн бүс – Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг

Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2007 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газар мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2007 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

2007 оны хувьд мал тооллогын холбогдолтой маягт, зааварт зарчмын өөрчлөлт ороогүй бөгөөд өмнөх жилүүдэд ашиглаж байсан мал тооллогын уламжлалт 10 маягт, зааврыг мөрдлөг болгон тооллогыг явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, тэдгээрийн экспорт болон мал эмнэлгийн арга хэмжээний талаар тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах, мөн усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хөдөөгийн хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа билээ.

Үүнтэй холбоотойгоор малжуулах болон усжуулах арга хэмжээний үр дүнг улсын хэмжээгээр нэгтгэн дүгнэх зорилгоор 2007 оны мал тооллоготой хамтруулан гурав дахь удаагаа зохион байгуулан явууллаа.

Түүнчлэн “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх шаардлагыг харгалзан тус хөтөлбөрөөс малжуулалт, усжуулалтын талаархи мэдээллийг цуглуулан авч дүгнэлт хийх хүсэлт тавьсныг мөн мал тооллогын ажилтай хамтатган гүйцэтгэлээ.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас газар тариаланг сэргээх зорилтыг хөдөө аж ахуйн бодлогын тэргүүлэх чиглэл болгон тавьж байгаа бөгөөд эдийн засгийн нөөцөө зохистой ашиглаж, техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд гол бодлогоо чиглүүлж байна. Үүнтэй холбоотойгоор газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийн талаархи мэдээллийг нэгтгэн тусгав.

Танилцуулгыг улсын дүн, бүсчилсэн байдлаар Баруун, Хангай, Төв, Зүүн бүс болон Улаанбаатар гэсэн бүсүүдээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай улсын хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.


Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас ихээхэн хамааралтай өвөрмөгц үйлдвэрлэл бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг явуулахад гол түүхий эд болдог онцлогтой.

Өнөөдөр дэлхийн хүн амын 45.0 орчим хувь нь хөдөөд амьдарч, амьдралын эх үүсвэр нь хөдөө аж ахуйн салбараас хамааралтай байгаа бөгөөд дэлхийн хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүний 5.0 орчим хувь, худалдааны эргэлтийн 7.0 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар үйлдвэрлэж бөгөөд эдгээр үзүүлэлтүүд манай орны адил хөгжиж байгаа орнуудын хувьд харьцангуй өндөр хэвээр байна.

Манай улсын хувьд ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий 20.0 орчим хувь, экспортын орлогын 10.0 гаруй хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, ажиллах хүчний 30.0 гаруй хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1

ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь



*- урьдчилсан гүйцэтгэлээр

Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар нь үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

I. МАЛ АЖ АХУЙ

I.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1147.0 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 919.9 тэрбум төгрөгт хүрч, 2006 онтой харьцуулахад оны үнээр 37.5 хувиар, зэрэгцүүлэх үнээр 17.1 хувиар өслөө /Хүснэгт 1/.

Энэхүү өсөлтөд 2007 онд цаг агаарын байдал тааламжтай байж, 2006 онтой харьцуулахад малын хорогдол 182.3 мянган толгойгоор буурч, бойжуулсан төлийн тоо 1989.0 мянга, малын тоо 5.5 сая толгойгоор өссөн нь голлон нөлөөллөө.

Мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо 2007 онд 12767.6 мянга, үүний дотор тэмээ 34.8 мянга, унага 431.0 мянга, тугал 688.1 мянга, хурга 5857.0 мянга, ишиг 5756.6 мянган толгойд хүрч, түүхэндээ анх удаа хамгийн олон төл бойжуулсан жил боллоо.

**Мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн
бүтээгдэхүүний үйлдвэрлэлт**

тэрбум төг.

	2006	2007	2007/2006	
			%	зөрүү
Тайлант оны үнээр	834.5	1147.0	137.5	312.5
2005 оны зэрэгцүүлэх үнээр	785.7	919.9	117.1	134.1

Мал аж ахуйн салбарт 2007 онд нядалгааны жингээр 188.2 мянган тонн мах, 465.6 мянган тонн сүү, 19.2 мянган тонн ноос, 4.9 мянган тонн ноолуур, 7.2 сая ширхэг арьс шир үйлдвэрлэлээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 17.4 мянган тонн, сүүний үйлдвэрлэл 15.5 мянган тонн, ноосны үйлдвэрлэл 2.4 мянган тонн, ноолуур үйлдвэрлэл 0.7 мянган тонноор, арьс шир үйлдвэрлэл 0.7 сая ширхэгээр өссөн байна /Хүснэгт 2/.

Хүснэгт 2

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

	2006	2007	2007/2006	
			%	зөрүү
Мах,нядалгааны жингээр, мян.тн	170.8	188.2	110.2	17.4
Тэмээний	6.1	5.3	86.9	-0.8
Адууны	31.9	29	90.9	-2.9
Үхрийн	44.2	46.6	105.4	2.4
Хонины	55.4	68.4	123.5	13.0
Ямааны	33	38.6	117.0	5.6
Сүү, мян.тн	450.4	465.6	103.4	15.4
Ингэний	4.1	3.8	92.7	-0.3
Гүүний	51.6	51.6	100.0	0.0
Үнээний	293.7	307.8	104.8	14.1
Хонины	32.4	32.9	101.5	0.5
Ямааны	68.4	69.6	101.8	1.2
Ноос, ноолуур, тн	22392.7	25578.2	114.2	3185.5
Тэмээний ноос	979.0	975.6	99.7	-3.4
Хонины ноос	15814.0	18174.8	114.9	2360.9
Ямааны ноолуур	4275.0	4938.1	115.5	663.3
Арьс, мян.шир	6374.0	7219.3	113.3	845.3
Тэмээ	31.8	26.8	84.3	-5.0
Адуу	273.2	269.1	98.5	-4.2
Үхэр	383.8	410.7	107.1	27.1
Хонь	2935.5	3498.5	119.2	563.0
Ямаа	2455.3	2807.3	114.3	352.0

Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн. 2007 онд нэг хүнд дунджаар 72.1 кг мах, 178.1 кг сүү ногдож, өнгөрсөн онтой харьцуулахад мах 5.9 кг-аар, сүү 3.5 кг-аар тус тус нэмэгдсэн байна. Түүнчлэн хүн амын хүнсэнд голлон хэрэглэгдэж буй нэг хүнд ногдох үхэр, хонины махны хэмжээ 2006 оныхоос 3.5 кг-аар өссөн байна.

Нэг хүнд ногдох мах сүүний хэмжээг хөрш орон Хятад, үүний дотор манай оронтой цаг агаарын хувьд төстэй Өвөр монголтой харьцуулан 2005 оны байдлаар авч үзсэн. Нэг хүнд ногдох үхэр, хонины мах манай улсад 40.0 кг, Хятад улсад 47.2 кг, Өвөр монголд 81.4 кг, сүү манай улсад 167.2 кг, Хятад улсад 21.1 кг, Өвөр Монголд 290.1 кг байна.

**Нэг хүнд ногдох хөдөө аж ахуйн
гол нэрийн бүтээгдэхүүн***

	кг			
	2004	2005	2006	2007
Мах, нядалгааны жингээр	77.5	72.2	66.2	72.1
Үүнээс: Үхэр, хонины мах	46.1	40.0	38.7	44.0
Сүү	161.3	167.2	174.6	178.1

Тайлбар: *-жилийн дундаж хүнд оногдуулж тооцноор

Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт. 2007 онд хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортоос 207.0 сая ам долларын орлого олсон байна.

2007 онд бэлтгэсэн хонины ноосны 50.0 хувь буюу 9.1 мянган тонн, бэлтгэсэн ямааны ноолуурын 66.7 хувь буюу 3.3 мянган тонн бохир, угаасан болон самнасан ноолуурыг тус тус экспортод гаргасан байна. Мөн 2007 онд бэлтгэсэн нийт арьс ширний 4.0 хувь буюу 277.8 мянган ширхэг арьсыг боловсруулалт хийлгүйгээр экспортод гаргасан байна.

Хүснэгт 3

Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт

Бүтээгдэхүүн, хэмжих нэгж	2006		Нэгжийн ду үнэ, ам.\$	2007*		Нэгжийн ду үнэ, ам.\$
	тоо, хэмжээ	үнийн дүн, мян.ам \$		тоо, хэмжээ	үнийн дүн, мян.ам \$	
Мах, тонн						
Үхрийн шинэ мах	194.6	309.1	1.6	-	-	
Үхрийн хөлдүү мах	2689.8	4425.0	1.6	3846.8	6212.9	1.6
Хонь, ямааны мах	0.3	0.5	1.7	76.9	151.7	2.0
Адууны мах	8814.3	10279.4	1.2	7072.8	9769.0	1.4
Малын дайвар бүтээгдэхүүн	1367.9	1564.1	1.1	1136.8	756.2	0.7
Сүү, цагаан идээ, кг						
Хуурай сүү	30.0	0.7	23.3	75.0	3.3	44.0
Тараг, цагаан идээ	164.0	2.3	14.0	15540.9	14.3	0.9
Бяслаг, аарц	42.0	0.3	7.1	-	-	-
Цэцгийн тос	20054.0	23.0	1.1	-	-	-
Ноос, ноолуур, тн						
Хонины ноос	6377.9	4545.4	0.7	9097.3	8425.7	0.9
Бохир ноолуур	4.5	47.5	10.6	-	-	-
Угаасан ноолуур	1671.2	63017.0	37.7	1509.0	63416.0	42.0
Самнасан ноолуур	1427.5	81740.6	57.3	1784.5	114277.0	64.0
Арьс, шир						
Адууны шир	302953.0	4872.8	16.1	236933.0	3812.8	16.1
Үхрийн шир	3502.0	63.0	18.0	46.0	1.0	21.7
Хонины арьс	-	-	-	40039.0	211.6	5.3

*-урьдчилсан гүйцэтгэл

Дэлхийн хэмжээнд нийт 16 орчим тонн ноолуур бэлтгэх боломжтой гэж үздэг бөгөөд Монгол Улс түүхий ноолуурын үйлдвэрлэлтээрээ дэлхийд хоёр дугаар байранд буюу Хятадын дараа орж, дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн 30 орчим хувийг бэлтгэж байна. Орос, Иран, Афганистан улсууд бага хэмжээний ноолуур бэлтгэн зах зээлд нийлүүлдэг байна.

2007 оны байдлаар нийт экспортын 6.0 хувийг самнасан ноолуур, 3.4 хувийг бохир ноолуур эзэлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар Монголд бэлтгэж буй ноолуурыг 100 хувь дотооддоо боловсруулалт хийвэл жилд 6.0 сая гаруй сүлжмэл эдлэл, 400.0 мянган ширхэг ноолууран хөнжил үйлдвэрлэх боломжтой байна. Гэтэл 2007 оны байдлаар дотоодын үйлдвэрт дөнгөж 667.1 мянган ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлэж, 1.6 мян тонн самнасан ноолуур, 20.9 тонн бөмбөгөн ноолуур боловсруулсан байна.

Ямааны ноолуур нь манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний хувьд ямааны ноолуурын чанарын талаархи зарим баримтыг авч үзье.

Манай улсад монгол ямаа, Завханы халтар ямаа, эрчмийн хар, баяндэлгэрийн улаан ямаа, өлгийн бор, говь гурван сайхан, уулын бор зэрэг ноолуурын чиглэлийн ямааг өсгөн үржүүлж байна.

Сүүлийн жилүүдэд ноолуурын гарцыг нэмэгдүүлэх үүднээс монгол ямааг олноор эрлийжүүлж, үүний үр дүнд ямааны ноолуурын гарц өссөн. Гэвч ноолуурын ширхэг бүдүүрч, будаг авдаггүй, завсрын үс нэмэгдсээр байна.

Монгол ямааны ноолуурын голч нь чанар, зэрэглэлээс хамааран 13.0-19.0 микроной байна.

Ноолуурын үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Хятад улсын ноолуурын чиглэлийн ямааны ихэнх нь ӨМӨЗО-д байдаг бөгөөд лионик, өвөр монголын цагаан ноолуурт, шиньзжяны цагаан ноолуурт, өвөр монголын үзэмчин ямаа зэргийг өсгөн үржүүлж, ноолуурын голч нь 14-16 микроной байна.

Эндээс харахад Хятад улс ноолуураар дэлхийд монополь өрсөлдөгч хэвээр байх бөгөөд Монгол улс ямааны ноолуурынхаа чанарын үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр анхаарвал дэлхийд эзлэх монгол ямааны байр суурь хэвээр хадгалагдах боломжтой.

Дотоодын үйлдвэрт боловсруулсан мал аж ахуйн бүтээгдэхүүн. 2007 онд дотоодын үйлдвэрүүдэд, нийт үйлдвэрлэсэн сүүний 2.0 хувьтай тэнцэх 9.5 мянган тонн сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан шингэн сүү, тараг, бяслаг, аарц, цөцгий зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Мөн нийт бэлтгэсэн махны 4.7 хувьтай тэнцэх 8.9 мянган тонн махыг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрийн аргаар боловсруулалт хийж мах, хиам, консерв зэрэг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Түүнчлэн нийт үйлдвэрлэсэн ноосны 8.7 хувьтай тэнцэх 1.7 мянган тонн угаасан ноос, ноолуурын 31.5 хувьтай тэнцэх 1.6 мянган тонн самнасан ноолуур үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

Мөн улсын хэмжээнд бэлтгэсэн үхрийн ширны 25.4 хувьтай тэнцэх 104.2 мянган ширхэг, хонины арьсны 20.6 хувьтай тэнцэх 722.4 мянган ширхэг, ямааны арьсны 8.5 хувьтай тэнцэх 238.3 мянган ширхэг үхэр, хонь, ямааны арьсыг тус тус дотоодын үйлдвэрт боловсруулсан байна.

Малын ашиг шимийн үзүүлэлт. Малын тоо, толгой нэмэгдэхийн хирээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, энэ нь малчдын орлого нэмэгдэх үндсэн эх сурвалж болж байна.

2004 онд мал бүхий нэг өрх жилд дунджаар мал аж ахуйгаас 2.5 сая орчим төгрөг олж байсан бол 2007 онд 5.1 сая орчим төгрөг болж, 2004 оныхоос 2.6 сая орчим төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Малын ашиг шимийн түүвэр судалгаагаар малын ашиг шимийн гарц бүсүүдэд ялгаатай байгаа хэдий ч нэг үнээнээс жилд дунджаар 497 литр сүү, ямаанаас 300 грамм ноолуур, тэмээнээс 3.8 кг ноос, хониноос 1.2 кг ноос ашиглаж байна.

2007 оны зах зээлийн үнээр үнэлж, мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир зэрэг бүтээгдэхүүнийг оруулж тооцоход нэг тэмээнээс 650.0 мянга орчим төгрөг, үхрээс 600.0 орчим мянган төгрөг, адуунаас 400.0 орчим мянган төгрөг, хониноос 60.9 мянган орчим төгрөг, ямаанаас 70.0 мянга орчим төгрөгийн орлогыг тус тус олсон байна.

Хүснэгт 4

**Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын
гаралтай бүтээгдэхүүн**

	Х/н	2006	2007	2007/2006	
				%	зөрүү
Боловсруулсан мах	тн	9980.4	8867.5	88.8	-1112.9
Боловсруулсан сүү	тн	6386.0	9476.0	148.4	3090.0
Угаасан ноос	тн	1107.8	1670.8	150.8	563.0
Самнасан ноос	тн	-	1.1	-	1.1
Самнасан ноолуур	тн	1388.2	1554.7	112.0	166.5
Адууны шир	ш	7125	-	-	-
Үхрийн шир	мян.ш	65.1	104.2	160.1	39.1
Хонины арьс	мян.ш	287.9	722.4	250.9	434.5
Ямааны арьс	мян.ш	260.7	238.3	91.4	-22.4

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ. 2007 онд манай улсын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээг тооцож үзвэл улсын хэмжээнд жилд 200.0 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 320.3 мянган тонн сүү, сүүн

бүтээгдэхүүний хэрэгцээтэй байсан бөгөөд хүн амын хүнсний гол хэрэглээ болох мах, сүүг хөдөө аж ахуйн салбараас бүрэн хангах боломжтой юм. 2007 онд улсын хэмжээнд нийт 200.0 орчим мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 481.9 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн байна. Эндээс харахад манай улс мах, махан бүтээгдэхүүнийг бүрэн, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг үндсэнд нь дотоодын үйлдвэрлэлээр хангажээ.

I.2 Мал тооллогын 2007 оны дүн

I.2.1 Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

Малтай өрх, малчдын тоо. Улсын хэмжээгээр 2007 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 226.1 мянган өрх тоологдсон байна. Үүний 75.9 хувь буюу 171.6 мянган өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 24.1 хувь нь буюу 54.5 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2007 оны дүнгээр мал тооллогын 366.2 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 48.5 хувь нь 16-34 насны, 38.7 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 12.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 16-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, харин 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхны эзлэх хувийн жин өссөөр байна.

Хүснэгт 5

Өрх, малчдын тоо, насны бүтэц

	2003	2004	2005	2006	2007
1. Малтай өрх, (мян.)	236.2	229.4	225.4	225.3	226.1
2. Малчин өрх, (мян.)	172.4	169	168.3	170.8	171.6
3. Малчдын тоо (мян.)	377.9	369.7	364.3	364.4	366.2
үүнээс: -16-34 насны	201.8	192.8	184.5	180.5	177.7
- эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны	126.6	127.7	131.8	137.9	141.9
- Тэтгэврийн насны	49.6	49.1	48	45.9	46.7
4. Нийт малчдаас эмэгтэй	161	158.6	155.5	160.6	166.1
5. Насны бүтэц %	100.0	100.0	100.0	100.0	100.0
үүнээс: -16-34 насны	53.4	52.2	50.6	49.5	48.5
- эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны	33.5	34.6	36.2	37.9	38.7
- Тэтгэврийн насны	13.1	13.3	13.2	12.6	12.8

2007 онд малчин өрхийн тоо 2006 онтой харьцуулахад 0.5 хувиар буюу 0.8 мянган өрхөөр өсчээ.

Малчин өрхийн тоо Булган, Төв, Завхан, Хэнтий, Өмнөговь, Ховд, Орхон, Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий, Баянхонгор аймгуудад 23-815-аар өсч, бусад аймгуудад 4-428-аар буурсан байна.

Бүсээр авч үзвэл малчин өрхийн тоо Хангай, Төв, Баруун бүсэд 505-582 өрхөөр өсч, Зүүн бүс болон Улаанбаатарт 377-457 өрхөөр буурсан байна.


Малчин өрхийн 29.1 хувь Баруун бүсэд, 40.4 хувь нь Хангайн бүсэд, 18.2 хувь нь Төвийн, 10.8 хувь нь Зүүн бүсэд, 1.5 хувь нь Улаанбаатарт тус тус ногдож байна.

2007 онд малчдын тоо 366.2 мянгад хүрч, 2006 онтой харьцуулахад 0.5 хувь буюу 1.8 мянгаар өссөн байна.

Аймгаар авч үзэхэд малчдын тоо Төв, Булган, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Архангай, Завхан, Дархан-Уул, Өмнөговь, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод 2006 оныхоос 148-2004-оор нэмэгдэж, бусад аймгуудад буурав.

Бүсээр авч үзвэл Хангайн болон Төвийн бүс, Улаанбаатарт малчдын тоо өсч, бусад бүсэд буурсан байна (Хавсралт 1, 2).

Малчдын тоо, насны бүлгээр, мян.



Малчдын нийгэм ахуйн үзүүлэлт. 2007 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 60.5 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 53.1 хувь нь телевизортой, 19.7 хувь нь авто машинтай, 31.3 хувь нь мотоцикльтой, 1.5 хувь нь трактортой, 65.1 хувь нь малын хашаатай, 17.8 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хангах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2007 онд 103.9 мянган болж, өнгөрсөн оныхоос 25.2 мянгаар буюу 32.0 хувиар нэмэгдэж, үүнтэй уялдаж телевизортой өрхийн тоо 20.9 мянгаар буюу 29.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн автомашинтай өрхийн тоо 2006 оныхоос 7.2 мянгаар буюу 27.1 хувиар, мотоцикльтэй өрхийн тоо 11.6 мянгаар буюу 27.7 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 6


Малчин өрхийн нийгэм ахуйн үзүүлэлтүүд

	Өрхийн тоо, мян.					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2003	2004	2005	2006	2007	2003	2004	2005	2006	2007
Цахилгаан үүсгүүртэй	28.9	53.7	67.7	78.7	103.9	16.7	31.8	40.2	46.1	60.5
Телевизортой	33.2	48.6	60.1	70.2	91.1	19.3	28.7	35.7	41.1	53.1
Автомашинтай	19.8	21.8	23.2	26.6	33.8	11.5	12.9	13.8	15.6	19.7
Мотоцикльтэй	33.4	35.7	37.8	42.0	53.6	19.4	21.1	22.2	24.6	31.3

Аймаг, бүсээр харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-аас харна уу.

Зураг 3

Малчин өрхийн нийгэм ахуйн үзүүлэлтүүд



2006 онд малчин өрхийн 46.1 хувь нь цахилгаан үүсгүүртэй байсан бол 2007 онд 60.5 хувь болж, цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 14.4 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 85.2 хувь нь нарны, 6.4 хувь нь салхины, 8.4 хувь нь бусад (бага оврын мотор, акумулятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна.

Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо

	Бүгд	Үүнээс			Дүнд эзлэх хувь		
		Нарны	Салхины	Бусад	Нарны	Салхины	Бусад
Цахилгаан үүсгүүртэй өрх	103882	88511	6672	8699	85.2	6.4	8.4

I.2.2 Мал, тэжээвэр амьтдын тоо, бүтэц

Малын тоо. 2007 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 40.3 сая толгойд хүрч, 2006 оныхоос 5.5 саяар буюу 15.7 хувиар, малын таван төрөл дээрээ өслөө. Төрлөөр авч үзвэл тэмээний тоо 260.6 мянга, адуу 2239.5 мянга, үхэр 2425.8 мянга, хонь 16990.1 мянга, ямаа 18347.8 мянгад хүрч, 2006 оныхоос тэмээ 7.1 мянга, адуу 124.7 мянга, үхэр 257.9 мянга, хонь 2175.0 мянга, ямаа 2896.1 мянган толгойгоор тус тус өслөө (Хавсралт 7, 8).

2007 онд нийт 600.0 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 24.7 хувийг эзэлж байна (Хавсралт 39). Сарлагийн тоо 2006 оныхоос 11.8 хувь буюу 63.5 мянган толгойгоор өссөн байна.

Хүснэгт 8

Малын тоо, төрлөөр

	МЯН.ТОЛ						
	2003	2004	2005	2006	2007	2007/2006	
						%	Зөрүү
Бүгд	25 427.7	28 027.9	30398.8	34802.9	40263.8	115.7	5460.9
Тэмээ	256.7	256.6	254.2	253.5	260.6	102.8	7.1
Адуу	1 968.9	2 005.3	2029.1	2114.8	2239.5	105.9	124.7
Үхэр	1 792.8	1 841.6	1963.6	2167.9	2425.8	111.9	257.9
Хонь	10 756.4	11 686.4	12884.5	14815.1	16990.1	114.7	2175.0
Ямаа	10 652.9	12 238.0	13267.4	15451.7	18347.8	118.7	2896.1

Малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 53.0 хувийг ямаа, 39.8 хувийг хонь, 4.7 хувийг үхэр, 2.3 хувийг адуу, 0.1 тэмээний өсөлт хангасан байна.

2007 онд нийт нутгаар байгаль, цаг уурын байдал тааламжтай байж, урьд онуудтай харьцуулахад харьцангуй олон төл бойжуулж, малын хорогдол бага гарсан нь малын тоо, толгой өсөхөд нөлөөллөө.

Мал тооллогын 2007 оны дүнгээр бүх аймаг, Улаанбаатар хотод 2006 онтой харьцуулахад малын тоо толгой өссөний дотор Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Увс, Ховд, Дархан-Уул аймаг малаа таван төрөл дээр нь өсгөсөн байна.

Нийт малын 30.6 хувь буюу 12301.7 мянган толгой нь Баруун бүсэд, 34.8 хувь буюу 14030.7 мянган толгой нь Хангай бүсэд, 20.9 хувь буюу 8400.2 мянга нь Төвийн бүсэд, 12.9 хувь буюу 5199.7 мянга нь Зүүн бүсэд, 0.8 хувь буюу 331.2 мянга нь Улаанбаатарт тус тус ногдож байна (Хавсралт 8).


Хүснэгт 9

Малын тоо, бүс нутгаар

	МЯН.ТОЛ						
	2003	2004	2005	2006	2007	2007/2006	
						%	Зөрүү
Дүн	25 427.8	28 028.1	30398.8	34802.9	40263.8	115.7	5460.9
Баруун	7 410.8	8 524.8	9242.1	10915.0	12301.7	112.7	1386.7
Хангай	8 131.8	9 050.9	10090.3	11852.6	14030.7	118.4	2178.1
Төв	5 723.7	6 252.8	6628.2	7071.2	8400.2	118.8	1329.0
Зүүн	3 918.2	3 973.2	4191.3	4642.1	5199.7	112.0	557.6
УБ	243.3	226.4	247	322.0	331.2	102.9	9.2

2007 онд тоологдсон малын тоог бүс тус бүрээр 2006 онтой харьцуулан авч үзэхэд Баруун бүсийн малын тоо 1386.7 мянга буюу 12.7 хувиар, Хангайн бүсийнх 2178.1 мянга буюу 18.4 хувиар, Төвийн бүсийнх 1329.0 мянгаар буюу 18.8 хувиар, Зүүн бүсийнх 557.6 мянга буюу 12.0 хувиар, Улаанбаатарынх 9.2 мянга буюу 2.9 хувиар тус тус өсчээ. Баруун, Хангай, Төвийн бүсийн малын тоо 5 төрөл дээрээ өсөв. Нийт малын тооны өсөлтийн 39.9 хувь нь Хангайн бүсийн, 25.4 хувийг Баруун бүсийн, 24.3 хувь нь Төвийн бүсийн, 10.2 хувь нь Зүүн бүсийн, 0.2 хувь нь Улаанбаатарын малын тооны өсөлтөөр хангагдсан байна.

Зураг 4



Таван төрлийн малын тооны өсөлт, бууралтыг 2006 онтой харьцуулан аймгаар авч үзэхэд тэмээ- 14 аймаг, Улаанбаатар хотод, адуу -18 аймагт, үхэр, хонь -20 аймаг, Улаанбаатар хотод, ямаа -21 аймаг, Улаанбаатар хотод тус тус өссөн байна.

2007 оны байдлаар нийт мал сүргийн 87.8 хувийг бог мал, 12.2 хувийг бод мал эзэлж байна.

Бүсээр авч үзэхэд Баруун бүсийн нийт малын 8.5 хувийг бод, 91.5 хувийг бог, Хангайн бүсийн нийт малын 13.5 хувийг бод, 86.5 хувийг бог, Төвийн бүсийн малын 11.8 хувийг бод, 88.2 хувийг бог, Зүүн бүсийн малын 17.8 хувийг бод, 82.2 хувийг бог, Улаанбаатарын малын 23.3 хувийг бод, 76.7 хувийг бог мал эзэлж байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 0.6, адуу 5.6, үхэр 6.0, хонь 42.2, ямаа 45.6 хувийг тус тус эзэлж байна. 2006 онтой харьцуулахад нийт мал сүрэгт ямаан сүргийн эзлэх хувийн жин 1.2 пунктээр өсч, бусад төрлийн малын эзлэх хувийн жин 0.1-0.5 пунктээр буурчээ.


Хүснэгт 10

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	2003	2004	2005	2006	2007
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	1.0	0.9	0.8	0.7	0.6
Адуу	7.7	7.2	6.7	6.1	5.6
Үхэр	7.1	6.6	6.5	6.2	6.0
Хонь	42.3	41.7	42.4	42.6	42.2
Ямаа	41.9	43.7	43.6	44.4	45.6

2007 оны байдлаар авч бог малын 48.1 хувийг хонь, 51.9 хувийг ямаа эзэлж байна.

Зураг 5




2007 онд улсад нийт мал болон үхрээр Хөвсгөл, тэмээгээр Өмнөговь, адуугаар Архангай, хониор Завхан, ямаагаар Говь-Алтай аймаг тэргүүлж байна (Хавсралт 6).

Бүсээр авч үзвэл нийт мал болон адуу, үхэр, хониор Хангайн бүс, ямаагаар Баруун бүс, тэмээгээр Төвийн бүс тэргүүлж байна.

Зураг 6

Малын тоо, аймгаар



Хувийн малын тоо. 2007 онд хувийн малын тоо 39.8 сая толгойд хүрч, нийт малын 98.7 хувийг эзэлж байна. Тэмээний 98.7 хувь, адууны 98.9, үхрийн 98.9, хонины 98.2, ямааны 99.2 хувь нь хувийн аж ахуйд байна (Хавсралт 10,11, 13). Хувийн малын тоо 2006 оныхоос 5437.0 мянгаар буюу 15.8 хувиар өслөө.

Хүснэгт 11

Хувийн малтай өрх, малын тоо

МЯН.ТОЛ

	Бүгд	Үүнээс				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	29529.0	343.8	2807.4	3485.4	12912.0	9980.5
1998	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8
1999	32278.7	346.4	3097.3	3733.2	14306.5	10795.3
2000	29236.7	315.5	2609.4	3028.3	13206.0	10077.5
2001	25335.6	278.3	2152.4	2031.8	11439.0	9434.2
2002	23280.0	247.2	1953.0	1853.4	10232.4	8994.1
2003	24888.8	251.8	1937.5	1768.3	10417.6	10513.5
2004	27517.5	252.1	1973.4	1817.0	11376.9	12098.1
2005	29901.8	250.0	2001.2	1940.3	12582.9	13127.4
2006	34315.0	249.7	2088.7	2142.3	14522.1	15312.2
2007	39752.0	257.1	2215.7	2398.0	16681.0	18200.2

2007 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 45.8 хувийг ямаа, 42.0 хувийг хонь, 6.0 хувийг үхэр, 5.6 хувийг адуу, 0.6 хувийг тэмээ эзэлж байна.

Мал бүхий 226.1 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 2007 онд 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 105.7 болж, 2006 оныхоос 11.7 мянган өрхөөр буюу 10.0 хувиар буурч, харин 100–гаас дээш малтай өрхийн тоо 120.5 мянгад хүрч, 2006 оныхоос 12.5 мянга буюу 11.5 хувиар өслөө (Хавсралт 4).

2007 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 46.7 хувь болж, 2006 оныхоос 5.4 пунктээр буурч, харин түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 53.3 хувь болж, 5.4 пунктээр нэмэгдсэн байна.

2007 оны байдлаар малтай өрхийн дийлэнх хувь буюу 70.8 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. Уг үзүүлэлт 2006 онд 75.3 хувьтай байсан бөгөөд 4.5 пунктээр буурсан байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт

Бүлэг	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо, мян.тол	
	2006	2007	2006	2007	2006	2007
Дүн	225366	226116	100.0	100.0	34315.1	39752.0
>10	21710	19326	9.6	8.5	123.0	109.8
11-30	27791	24373	12.3	10.8	570.6	506.1
31-50	24175	21002	10.7	9.3	987.8	852.6
51-100	43687	40962	19.4	18.1	3263.1	3086.3
101-200	52445	54441	23.3	24.1	7593.8	8014.7
201-500	44765	51200	19.9	22.6	13365.0	15676.9
501-999	8458	11460	3.8	5.1	5486.7	7317.4
1000-1499	2024	2922	0.9	1.3	2307.5	3325.6
1500-2000	182	251	0.1	0.1	305.5	419.7
2001+	129	179	0.1	0.1	312.1	442.9

Аймгаар авч үзэхэд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 2006 онд 59.1-95.6 хувьтай байсан бол 2007 онд 53.3-94.6 хувь болсон байна.

Бүсээр авч үзвэл, 2007 онд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт мал бүхий өрхөд эзлэх хувь Баруун бүсэд 68.2, Хангай бүсэд 73.1, Төвийн бүсэд 68.2 хувь, Зүүн бүсэд 68.2 хувь, Улаанбаатарт 94.6 хувь болж, 2006 оныхоос 1.0-5.2 пунктээр буурсан байна.

2007 онд 1000 ба түүнээс дээш малтай 3352 өрх тоологдож, 2006 оныхоос 1017 өрхөөр нэмэгдсэн байна. 1000-аас дээш малтай өрхийн 30.6 хувь нь Баруун бүсэд, 30.2 хувь нь Хангайн бүсэд, 19.7 хувь нь Төвийн бүсэд, 18.9 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

1000-аас дээш малтай өрхийн тоогоор Завхан аймаг тэргүүлж байна. (Хавсралт 5)

Хүснэгт 13

Малтай нэг өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

Бүлэг	1 өрхөд ногдох мал		Үүнээс:				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
	2006	2007					
Дүн	152	176	1	10	11	74	80
>10	6	6	0	1	3	1	1
11-30	21	21	0	2	5	5	9
31-50	41	41	0	3	6	12	20
51-100	75	75	0	5	7	25	38
101-200	145	148	1	8	10	54	75
201-500	299	306	2	16	15	127	146
501-999	649	639	4	34	28	310	263
1000-1499	1 140	1 139	5	61	48	625	400
1500-2000	1 679	1 673	8	107	69	914	575
2001+	2 420	2 474	9	162	111	1 428	764

Улсын дунджаар хувийн малтай нэг өрхөд 176 толгой мал ногдож байгаа нь 2006 оныхоос 24 толгой малаар илүү байна. Малтай нэг өрхөд тэмээ 1, адуу 10, үхэр 11, хонь 74, ямаа 80 ногдож байна.

1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 87.5 хувь нь бог мал, 12.5 хувь нь бод мал байна.

200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунджаар 79 толгой, 201-999 малтай нэг өрхөд 367 толгой, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1249 толгой мал тус тус ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо Дундговь, Говь-Сүмбэр, Говь-Алтай, Дорнод, Завхан, Хөвсгөл, Ховд, Өмнөговь, Төв, Увс, Сүхбаатар, Дорноговь, Хэнтий аймгуудад улсын дунджаас 6-66 толгойгоор дээгүүр, бусад аймагт 7-130 толгойгоор доогуур байна.

Бүсээр авч үзвэл, нэг өрхөд ногдох малын тоо Баруун, Төв, Зүүн бүсэд улсын дунджаас 6-24 толгойгоор илүү байна.

2007 оны байдлаар амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд нийт малын 89.9 хувь буюу 36.2 сая толгой мал байна.

Хүснэгт 14

Малчин өрхийн малын бүлэглэлт, 2007 онд

Бүлэг	Малчин өрхийн тоо	Малчин өрхийн малын тоо	үүнээс :				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
>10	6244	35.9	0.3	5.9	16.7	5.1	7.8
11-30	12953	274.8	1.6	29.0	67.2	65.7	111.4
31-50	13638	554.4	3.2	44.1	81.7	164.6	260.8
51-100	31043	2399.4	14.2	160.4	250.7	784.7	1189.5
101-200	47461	7037.6	49.5	406.4	479.7	2548.3	3553.7
201-500	46366	14718.5	113.5	771.0	723.2	6099.6	7011.2
501-999	10702	7102.8	44.8	373.2	304.3	3457.8	2922.7
1000-1499	2764	3252.7	15.0	172.0	136.5	1784.8	1144.4
1500-2000	247	412.5	2.1	26.5	16.7	223.7	143.4
2001+	170	426.8	1.6	28.0	19.1	249.0	129.2
Дүн	171588	36215.5	245.7	2016.5	2095.9	15383.2	16474.2

2007 оны байдлаар нэг малчин өрхөд дунджаар 211 толгой мал, үүний дотор тэмээ 1, адуу 12, үхэр 12, хонь 90, ямаа 96 тус тус ногдож байна.

Хүснэгт 15


Нэг малчин өрхөд ногдох малын тоо

Бүлэг	Бүгд	Үүнээс:				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Дүн	211	1	12	12	90	96
>10	6	0	1	3	1	1
11-30	21	0	2	5	5	9
31-50	41	0	3	6	12	19
51-100	76	0	5	8	25	38
101-200	149	1	9	10	54	75
201-500	318	2	17	16	132	151
501-999	663	4	35	28	323	273
1000-1499	1 176	5	62	49	646	414
1500-2000	1 670	9	107	68	905	581
2001+	2 511	9	165	112	1 465	760

Малчин өрхийн 37.2 хувь нь 100 хүртэл малтай, 27.7 хувь нь 101-200 хүртэл малтай, 27.0 хувь нь 201-500 малтай, 6.2 хувь нь 501-999 малтай, 1.9 хувь нь 1000-аас дээш малтай байна. Эндээс харахад малчин өрхийн талаас илүү хувь нь 200 хүртэл толгой малтай байна (Хавсралт 4.1).

Зураг 7

Малчин өрх, малын бүлэглэлтээр



Хээлтэгч мал, 2007 оны эцэст 16784.8 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2006 оныхоос 2072.4 мянган толгой буюу 14.1 хувиар өссөн байна.

Төрлөөр авч үзвэл хээлтэгч малын тоо бүх төрөл дээр өссөн бөгөөд ингэ 4.3 мянга, гүү 38.8 мянга, үнээ 92.3 мянга, эм хонь 879.2 мянга, эм ямаа 1057.8 мянган толгойгоор тус тус өссөн байна (Хавсралт 24).

Хүснэгт 16

Хээлтэгч малын тоо


	2003	2004	2005	2006	2007	2007/2006	
						%	Зөрүү
Бүгд	10804.8	11604.7	12883.7	14712.4	16784.8	114.1	2072.4
Ингэ	77.7	77.4	76.3	76.8	81.0	105.5	4.3
Гүү	580.2	571.8	569.7	594.0	632.8	106.5	38.8
Үнээ	721.4	733.3	764.3	839.4	931.7	111.0	92.3
Эм хонь	4853.2	5147.5	5751.8	6611.5	7490.7	113.3	879.2
Эм ямаа	4572.4	5074.8	5721.8	6590.7	7648.5	116.1	1057.8

Хээлтэгч мал нийт малын 41.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 31.1 хувь, адуун сүргийн 28.3 хувь, үхэр сүргийн 38.4 хувь, хонин сүргийн 44.1 хувь, ямаан сүргийн 41.7 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийг хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохиомжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 4 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 32.6, бог малд 43.3 хувь байна.

Зураг 8

Хээлтэгч малын тоо, мян.тол



Аймгаар авч үзвэл хээлтэгч малын тоо нь Дорноговь аймагт 8.7 мянган толгой буюу 2.5 хувиар буурч, бусад аймгуудад 2.3-204.9 мянган толгойгоор буюу 1.5-30.7 хувиар нэмэгджээ (Хавсралт 25).

Бүсээр авч бүх бүсэд хээлтэгч малын тоо 1.5-17.6 хувь буюу 2.3-865.3 мянган толгойгоор өссөн байна. Зүүн бүсийн нийт малын 43.6 хувь, Баруун болон Хангайн бүсийн нийт малын 41.2 хувь, Төвийн бүсийн нийт малын 41.8 хувь, Улаанбаатарын нийт малын 45.9 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Төл бойжилт. 2007 оны байдлаар оны эхний эх малын 88.8 хувь буюу 13071.0 мянган эх мал төллөж, гарсан төлийн 97.1 хувийг буюу 12767.6 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2006 оныхоос 1989.0 мянган толгойгоор нэмэгдэж, бойжилтын хувь 1.8 пунктээр өссөн байна.

Гарсан ботгоны 95.7 хувь, унаганы 94.7 хувь, тугалын 97.3 хувь, хурганы 97.7, ишигний 96.8 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад бүх төрөл дээрээ 1.5-1026.1 мянган толгойгоор өссөн байна.


Төл бойжилт

	Бүгд			Үүнээс:				
	2005	2006	2007	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	9913.7	11309.0	13143.5	36.4	454.9	707.0	5996.6	5948.6
Бойжсон төл	9333.0	10778.6	12767.6	34.8	431.0	688.1	5857.0	5756.6
Бойжилтын хувь	94.1	95.3	97.1	95.7	94.7	97.3	97.7	96.8

2007 онд бойжуулсан төлийн тоо бүх аймагт 8.4-168.3 мянган толгойгоор өссөн байна (Хавсралт 27).

Зураг 9

Бойжуулсан төлийн тоо, мян.тол



Бойжуулсан төлийг бүсээр авч үзвэл, бүх бүсэд бойжуулсан төлийн тоо 17.6-696.4 мянган толгойгоор нэмэгджээ.

Нийт бойжуулсан төлийн 31.0 хувь нь Баруун бүсэд, 34.0 хувь нь Хангайн бүсэд, 20.7 хувь нь Төвийн бүсэд, 13.4 хувь нь Зүүн бүсэд, 0.9 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Хүснэгт 18

Бойжуулсан төл

	МЯН.ТОЛ				
	2003	2004	2005	2006	2007
Бүгд	7885.5	9296.1	9333.0	10778.6	12767.6
Ботго	31.7	35.8	34.6	33.3	34.8
Унага	306.3	384.1	387.4	394.1	431.0
Тугал	512.8	549	569.3	611.6	688.1
Хурга	3761.0	4250.4	4372.8	5009.1	5857.0
Ишиг	3273.7	4076.8	3968.9	4730.5	5756.6

2007 онд улсын дунджаар 100 эхээс 87 төл бойжуулсан нь 2006 оныхоос 3 төлөөр нэмэгдэв.

Дорноговь, Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ, Баянхонгор, Сүхбаатар, Архангай, Говьсүмбэр, Орхон аймгуудад 100 эхээс бойжуулсан төлийн тоо 1-48 толгойгоор нэмэгдэж, бусад аймагт 2-7 толгойгоор буурсан байна (Хавсралт 28).

Хүснэгт 19

100 эхээс бойжуулсан төл


	ТОЛ.				
	2003	2004	2005	2006	2007
Бүгд	75	86	80	84	87
Ботго	42	46	45	44	45
Унага	52	66	68	69	73
Тугал	66	76	78	80	82
Хурга	77	88	85	87	89
Ишиг	78	89	78	83	87

Бүсээр авч үзвэл, Хангай, Төв болон Зүүн бүсэд 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2006 оныхоос 1-15 толгойгоор өсч, харин Баруун бүс, Улаанбаатарт 3-7 толгойгоор буурсан байна.

Улсын дундажтай харьцуулахад Баруун болон Хангайн бүсэд 100 эхээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас дээгүүр, Төвийн болон Зүүн бүс, Улаанбаатарт доогуур байна.

Зураг 10

100 эхээс бойжуулсан төл



Том малын зүй бус хорогдол. 2007 онд, оны эхний нийт малын 0.8 хувьтай тэнцэх 294.1 мянган толгой мал хорогдсон нь 2006 оныхоос 182.3 мянгаар буюу 38.2 хувиар буурсан байна. Нийт хорогдсон малын 40.8 хувийг хонь, 40.7 хувийг ямаа, 9.5 хувийг үхэр, 8.4 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

Нийт хорогдлын 14.9 хувь буюу 43.8 мянга нь гэнэтийн аюулаар, 85.1 хувь буюу 250.3 мянга нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ.

Хүснэгт 20

Том малын зүй бус хорогдол


	МЯН.ТОЛ				
	2003	2004	2005	2006	2007
Бүгд	1324.3	291.7	677.2	476.4	294.1
Тэмээ	7.3	2.4	3.7	4.7	2.0
Адуу	136.7	31.0	39.1	30.6	24.6
Үхэр	215.4	46.0	58.1	39.5	27.9
Хонь	536.6	116.0	255.7	182.2	119.9
Ямаа	428.4	96.3	320.7	219.3	119.8

Том малын зүй бус хорогдол Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хэнтий, Өвөрхангай, Архангай, Дорнод, Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хотод 2006 оныхоос 0.4 -125.2 мянган толгойгоор буурч, бусад аймагт 1.7-15.3 мянган толгойгоор нэмэгдсэн байна (Хавсралт 29).

Нийт хорогдлын 59.8 хувь нь Увс, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Баян-Өлгий, Баянхонгор аймагт ногдож байна.

Зураг 11

Том малын зүй бус хорогдол



Бүсээр авч үзвэл, Хангай, Төв, Зүүн бүс, Улаанбаатарт хорогдлын хэмжээ 0.5-203.1 мянган толгойгоор буурч, харин Баруун бүсэд 33.2 мянган толгойгоор өссөн байна.

Нийт хорогдлын 36.2 хувь нь Баруун бүсэд, 29.4 хувь нь Хангайн бүсэд, 21.0 хувь нь Зүүн бүсэд, 12.8 хувь нь Төвийн бүсэд гарсан байна.

Хүснэгт 21

Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2003	2004	2005	2006	2007
Бүгд	5.5	1.1	2.4	1.6	0.8
Тэмээ	2.9	1.0	1.4	1.9	0.8
Адуу	6.9	1.6	1.9	1.5	1.2
Үхэр	11.4	2.6	3.2	2.0	1.3
Хонь	5.0	1.1	2.2	1.4	0.8
Ямаа	4.7	0.9	2.6	1.7	0.8

Зүүн бүсэд оны эхний малын 1.3 хувь, Баруун бүсэд 1.0 хувь, Хангайн бүсэд 0.7 хувь, Төв болон Улаанбаатарт 0.5 хувь нь хорогдсон байна.

2007 онд 43.8 мянган мал гэнэтийн аюулаар хорогдсон нь 2006 оныхоос 29.2 мянган толгойгоор буюу 40.0 хувиар буурсан байна (Хавсралт 30).

Хүснэгт 22

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2003	2004	2005	2006	2007
Бүгд	643.3	39.6	123.5	73.0	43.8
Тэмээ	1.1	0.2	0.4	0.5	0.2
Адуу	65.9	3.4	5.1	5.0	2.9
Үхэр	107.6	4.6	10.4	5.2	3.8
Хонь	267.9	17.3	48.6	29.1	20.2
Ямаа	200.9	14.2	59.1	33.3	16.8

мян.тол

Гэнэтийн аюулаар хорогдсон малын 31.4 хувь нь Увс аймагт, 23.9 хувь нь Сүхбаатар аймагт, 11.2 хувь нь Баянхонгор аймагт гарсан байна.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын 37.0 хувь нь Баруун бүсэд, 33.3 хувь нь Зүүн бүсэд, 18.0 хувь нь Хангайн бүсэд, 10.1 хувь нь Төвийн бүсэд тус тус ногдож байна.

Малын хээл хаялт, сувайралт. 2007 онд оны эхний хээлтэгч малын 8.0 хувьтай тэнцэх 1.2 сая мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо 2006 оныхоос 3.9 хувь буюу 48.0 мянгаар буурчээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын 73.1 хувь буюу 865.9 мянга нь сувайрсан хээлтэгч, 26.9 хувь буюу 317.9 мянга нь хээл хаясан эх мал байна.

Хүснэгт 23

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо

мян.тол

	Сувайрсан				Хээл хаясан			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Бүгд	700.1	820.7	898.9	865.9	251.8	512.9	332.9	317.9
Ингэ	2.9	3.1	2.9	2.4	0.5	0.6	0.5	0.3
Гүү	99.3	85.8	85.2	83.2	29.7	26.4	24.8	20.1
Үнээ	93.7	82.8	84.9	88.7	25.6	26.4	20.5	22.2
Эм хонь	260.7	310.4	314.1	330.9	90.8	105.8	98.5	100.7
Эм ямаа	243.5	338.7	411.8	360.7	105.2	353.6	188.7	174.6

Аймгаар авч үзвэл, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Орхон, Баянхонгор, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорнод аймагт төл өгөөгүй хээлтэгч

малын тоо 0.7-90.8 мянган толгойгоор буурч, бусад аймгуудад 0.2-45.3 мянгаар нэмэгджээ (Хавсралт 31, 32).

Хүснэгт 24

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

	Сувайрсан				Хээл хаясан			2007
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	
Бүгд	6.5	7.1	7.0	5.9	2.3	4.4	2.6	2.2
Ингэ	3.7	4.0	3.8	3.1	0.6	0.7	0.6	0.4
Гүү	17.1	15.0	15.0	14.0	5.1	4.6	4.3	3.4
Үнээ	13.0	11.3	11.1	10.6	3.6	3.6	2.7	2.6
Эм хонь	5.4	6.0	5.5	5.0	1.9	2.1	1.7	1.5
Эм ямаа	5.3	6.7	7.2	5.5	2.3	7.0	3.3	2.6

Хээл хаяж, сувайрсан эх малын 25.6 хувь нь Баруун, 32.5 хувь нь Хангайн, 25.6 хувь нь Төвийн, 15.2 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. 2007 онд 375.3 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2006 оныхоос 37.3 мянган толгойгоор буюу 11.0 хувиар өсчээ.

Хүснэгт 25

Хээлтүүлэгч малын тоо

	2003	2004	2005	2006	2007
Бүгд	295.9	296.1	309.2	338.0	375.3
Буур	3.8	3.5	3.3	3.3	3.4
Азарга	89.5	85.8	83.5	83.7	86.0
Бух	26.5	26.0	27.7	31.0	34.7
Хуц	91.0	91.3	101.2	110.8	125.5
Ухна	85.1	89.5	93.5	109.2	125.7

мян.тол

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 2007 онд улсын дунджаар 60-61 эм хонь, ямаа ногдож, 2 дахин өндөр үзүүлэлт гарч байна (Хавсралт 33).

Хүснэгт 26

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

	Үржлийн норм	2003	2004	2005	2006	2007
Ингэ	20-25	21	22	23	24	24
Гүү	12-15	7	7	7	7	7
Үнээ	35-45	27	28	28	27	27
Эм хонь	25-30	53	53	57	60	60
Эм ямаа	25-30	54	51	61	60	61

Малын хэрэглээний зарлага. 2007 онд оны эхний нийт малын 20.1 хувьтай тэнцэх 7012.6 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2006 оныхоос 1114.6 мянган толгойгоор өссөн байна (Хавсралт 37).

Малтай нэг өрх дунджаар 31 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна.

Үүнийг улсын хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дунджаар 11 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

	МЯН.ТОЛ				
	2003	2004	2005	2006	2007
Бүгд	5034.5	6404.9	6284.0	5898.0	7012.6
Тэмээ	20.7	33.3	33.4	29.6	25.7
Адуу	193.6	317.6	324.5	277.8	281.6
Үхэр	388.7	454.2	389.2	367.6	402.3
Хонь	3104.4	3204.3	2918.2	2896.0	3562.2
Ямаа	1327.1	2395.5	2618.8	2326.9	2740.7
Оны эхний малд эзлэх хувь					
Бүгд	21.1	25.2	22.4	19.4	20.1
Тэмээ	8.2	13.0	13.0	11.5	10.2
Адуу	9.7	16.1	16.2	13.7	13.3
Үхэр	20.6	25.3	21.1	18.7	18.6
Хонь	29.2	29.8	25.0	22.5	24.0
Ямаа	14.5	22.5	21.4	17.5	17.7

Оны эхний тэмээний 10.2 хувь, адууны 13.3 хувь, үхрийн 18.6 хувь, хонины 24.0 хувь, ямааны 17.7 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 89.9 хувийг бог мал, 10.1 хувийг бод мал эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд тэмээний хэрэглээний зарлага буурч байсан нь тэмээний тоо толгой өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 28

Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоод хэрэглэсэн малын тоо

	Зах зээлд худалдан борлуулсан				Аж ахуйн дотоод хэрэглэсэн			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Бүгд	2230.2	2317.6	2214.6	2672.5	2877.6	2829.2	2692.6	2957.0
Тэмээ	10.9	11.4	9.8	9.9	12.8	12.5	11.2	10.0
Адуу	120.5	132.4	128.5	131.1	129.1	123.1	107.9	105.7
Үхэр	180.6	156.4	157.3	170.6	187.0	175.7	160.0	167.9
Хонь	1110.6	1108.7	1107.5	1395.9	1364.6	1265.8	1254.0	1405.4
Ямаа	807.6	908.7	811.5	965.0	1184.1	1252.1	1159.5	1268.0

Хэрэглээнд зарцуулсан малын 38.2 хувийг зах зээлд худалдан борлуулж, 42.2 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулжээ.

Бүсээр авч үзвэл, Баруун бүсэд оны эхний малынхаа 22.6 хувь, Хангайн бүсэд 17.5 хувь, Төвийн бүсэд 18.0 хувь, Зүүн бүсэд 23.4 хувь, Улаанбаатард 32.9 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 35.2 хувь нь Баруун, 29.6 хувь нь Хангайн бүсэд, 18.2 хувь нь Төвийн бүсэд, 15.5 хувь нь Зүүн бүсэд, 1.5 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Малтай нэг өрх дунджаар 12 толгой малыг зах зээлд борлуулж, 13 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэжээ.

Сүргийн бүтэц. 2007 оны байдлаар нийт сүргийн 33.3 хувь буюу 13417.9 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 24.1 хувь буюу 9685.9 мянган толгой нь нас гүйцсэн мал, 41.7 хувь буюу 16784.7 мянган толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 375.3 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна (Хавсралт 16-21).

Хүснэгт 29

2007 оны сүргийн бүтэц

	Толгойгоор, мян.тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Бүгд	40263.3	13417.9	9685.9	16784.8	375.3	100.0	33.3	24.1	41.7	0.9
Тэмээ	260.6	94.1	82.0	81.0	3.4	100.0	36.1	31.5	31.1	1.3
Адуу	2239.5	854.3	666.4	632.8	86.0	100.0	38.1	29.8	28.3	3.8
Үхэр	2425.8	1135.5	324.0	931.7	34.7	100.0	46.8	13.4	38.4	1.4
Хонь	16990.1	5743.8	3630.1	7490.7	125.5	100.0	33.8	21.4	44.1	0.7
Ямаа	18347.8	5590.2	4983.4	7648.5	125.7	100.0	30.5	27.2	41.7	0.7

2007 онд төл, өсвөр нас, нас гүйцсэн малын сүрэгт эзлэх хувь 0.2-0.4 пунктээр нэмэгдэж, харин хээлтэгч, хээлтүүлэгчийн нийт сүрэгт эзлэх хувь 0.1-0.6 пунктээр буурчээ.

Хүснэгт 30

Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны				Нас гүйцсэн эр			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Бүгд	34.8	32.7	33.1	33.3	22.7	23.9	23.7	24.1
Тэмээ	32.0	35.2	35.8	36.1	36.4	33.5	32.7	31.5
Адуу	34.3	36.7	37.7	38.1	32.9	31.1	30.3	29.8
Үхэр	46.1	47.1	47.1	46.8	12.7	12.5	12.8	13.4
Хонь	35.2	33.5	33.5	33.8	19.9	21.1	21.2	21.4
Ямаа	32.8	29.2	30.0	30.5	25.0	26.9	26.6	27.2

	Хээлтэгч				Хээлтүүлэгч			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Бүгд	41.4	42.4	42.3	41.7	1.1	1.0	1.0	0.9
Тэмээ	30.2	30.0	30.3	31.1	1.4	1.3	1.3	1.3
Адуу	28.5	28.1	28.1	28.3	4.3	4.1	4.0	3.8
Үхэр	39.8	38.9	38.7	38.4	1.4	1.4	1.4	1.4
Хонь	44.0	44.6	44.6	44.1	0.8	0.8	0.7	0.7
Ямаа	41.5	43.1	42.7	41.7	0.7	0.7	0.7	0.7

I.2.3 Эрчимжсэн мал аж ахуй

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2007 онд цэвэр үүлдрийн 1997.4 мянган мал, эрлийз 475.8 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 1601.0 мянган мал, нутгийн шилмэл омгийн 745.6 мянган мал тоологдов.

2006 онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 12.0 хувиар буюу 214.4 мянган толгойгоор, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 7.6 хувь буюу 113.5 мянган толгойгоор өсч, эрлийз мал 5.8 хувь буюу 29.2 мянган толгойгоор, нутгийн шилдэг омгийн мал 3.7 хувь буюу 28.7 мянган толгойгоор тус тус буурсан байна.

Хүснэгт 31

Цэвэр үүлдрийн болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо

	2003	2004	2005	2006	2007	2007/2006	
						%	зөрүү
						МЯН.ТОЛ	
Цэвэр үүлдрийн	1161.0	1211.3	1520.7	1783.0	1997.4	112.0	214.4
Үхэр	15.7	26.5	21.7	30.2	33.1	109.6	2.9
Хонь	975.3	1013.1	1205.2	1411.0	1574.7	111.6	163.7
Ямаа	170.0	171.7	293.8	341.8	389.6	114.0	47.8
Эрлийз	380.4	450.4	356.9	505.0	475.8	94.2	-29.2
Үхэр	57.9	53.5	55.5	62.3	67.9	109.0	5.6
Хонь	68.1	73.7	53.9	57.7	59.9	103.8	2.2
Ямаа	254.4	323.2	247.5	385.0	348.0	90.4	-37.0
Нутгийн шилдэг омгийн	572.8	708.4	697.4	774.3	745.6	96.3	-28.7
Тэмээ	5.2	5.3	7.3	8.7	9.4	108.0	0.7
Адуу	19.0	21.4	16.5	25.3	27.7	109.5	2.4
Үхэр	2.5	0.7	0.5	2.1	0.1	4.0	-2.0
Хонь	65.5	81.6	113.0	103.9	65.2	62.8	-38.7
Ямаа	480.6	599.4	560.1	634.3	643.2	101.4	8.9
Сайжруулсан нутгийн үүлдрийн	1111.5	1177.5	1280.0	1487.5	1601.0	107.6	113.5
Тэмээ	0.5	0.7	1.3	0.5	0.7	140.0	0.2
Адуу	10.2	12.6	21.3	10.2	10.3	101.0	0.1
Үхэр	21.8	23.2	27.9	19.8	20.3	102.5	0.5
Хонь	738.8	719.0	753.3	892.7	918.4	102.9	25.7
Ямаа	340.2	422.0	449.6	564.3	651.3	115.4	87.0

Нийт малын 5.0 хувийг цэвэр үүлдрийн мал, 1.2 хувийг эрлийз үүлдрийн мал, 1.9 хувийг нутгийн шилдэг омгийн мал, 4.0 хувийг сайжруулсан нутгийн үүлдрийн мал тус тус эзэлж байна (Хавсралт 34, 35)

Эрчимжсэн фермерийн аж ахуй. Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимжсан фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна.

ХХААЯ-наас хүн ам төвлөрсөн томоохон хот, суурин газрын орчимд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор 2007 онд 56 иргэн, аж ахуйн нэгжид 665.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 32

Эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо

	2005	2006	2007	2007/2006	
				%	зөрүү
Бүгд	284	599	750	125.2	151
Сүүний үхрийн ферм	186	395	494	125.1	99
Махны үхрийн ферм	11	7	10	142.9	3
Мах, ноосны хонины ферм	12	13	15	115.4	2
Гахайн ферм	21	72	79	109.7	7
Тахиан ферм	38	81	111	137.0	30
Зөгийн ферм	16	31	40	129.0	9
Туулайн ферм	-	-	1	-	-

2007 оны байдлаар улсын хэмжээнд 750 эрчимжсэн аж ахуй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад фермерийн аж ахуйн тоо 151-ээр буюу 25.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 33

Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа фермерийн аж ахуйд өсгөн үржүүлж байгаа малын тоо

	Сүүний үхэр			Махны үхэр			Мах, ноосны хонь		
	Фермерийн аж ахуйн тоо	үхрийн тоо	1 фермерийн аж ахуйд ногдох үхэр	Фермерийн аж ахуйн тоо	үхрийн тоо	1 фермерийн аж ахуйд ногдох үхэр	Фермерийн аж ахуйн тоо	малын тоо	1 фермерийн аж ахуйд ногдох хонь
2006	395	8012	20	7	1334	191	13	6750	519
2007	494	10070	20	10	1705	171	15	7350	490

үргэлжлэл

	Гахай			Тахиа			Зөгий		
	фермерийн аж ахуйн тоо	Гахайны тоо	1 фермерийн аж ахуйд ногдох гахай	Фермерийн аж ахуйн тоо	тахиааны тоо	1 фермерийн аж ахуйд ногдох тахиа	Фермерийн аж ахуйн тоо	Зөгийн тоо, бүл	1 фермерийн аж ахуйд ногдох зөгий, бүл
2006	72	8948	124	81	390173	2350	31	1221	39
2007	79	10000	127	111	395200	3560	40	1667	42

2007 онд сүүний чиглэлийн нэг фермерийн аж ахуйд 20 толгой үхэр, махны чиглэлийн нэг фермерийн аж ахуйд 171 толгой үхэр, мах, ноосны чиглэлийн нэг

фермерийн аж ахуйд 490 толгой хонь, гахайн нэг фермерийн аж ахуйд 127 гахай, тахианы нэг фермерийн аж ахуйд 3560 тахиа, зөгийн нэг фермерийн аж ахуйд 42 бүл зөгий ногдож байна.

ХХААЯ-ны мэдээгээр эдгээр эрчимжсэн фермерийн аж ахуй нь жилд нэг үнээнээс 1210-2230 л сүү, нэг өндөглөгчөөс 160-290 ширхэг өндөг, нэг бүл зөгийнөөс 10 кг бал, нэг хониноос 2.8-3.6 кг нарийн, нарийвтар ноос ашиглаж байгаа мэдээтэй байна.

Эрчимжсэн фермерийн аж ахуйн 32.0 хувь нь Улаанбаатар хотод, 26.8 хувь нь Төв аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа болно (Хавсралт 36).

1.2.4 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

Бэлчээрийн хүрэлцээ. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2007 оны газрын нэгдмэл сангийн урьдчилсан тайлангаар манай улсын бэлчээр хадлангийн талбай 113.5 сая га талбайд хүрч, 2006 оныхоос 0.04 хувиар буюу 47.6 мянган га-гаар буурсан байна.

Хүснэгт 34


Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2002	2003	2004	2005	2006	2007
Хадлан бэлчээрийн талбай, сая га	128.9	113.1	112.8	113.4	113.6	113.5
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	35	41	44	46	51	57

2007 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 57 толгой мал ногдож, өмнөх оныхоос 6 толгойгоор буюу 11.7 хувиар нэмэгджээ. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөхийн хэрээр 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох малын тоо өссөөр байна.

Зураг 12

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо



Хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо Орхон аймагт 865, Улаанбаатарт 273, Дархан-уул аймагт 206, Архангай аймагт 151, Булган аймагт 136, Хөвсгөл аймагт 131 толгой байгаа нь бусад аймаг болон улсын дундажтай харьцуулахад өндөр байна (Хавсралт 39)

Бүсээр авч үзвэл, Хангайн бүс, Улаанбаатарт 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 92-273 толгой мал ногдож энэ улсын дунджаас 35-216 толгойгоор өндөр байна.

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 2007 онд улсын хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 513.4 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь 2006 оныхоос 4.2 хувь буюу 22.5 мянган тонноор буурав. Бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр авч үзвэл сүрэл, гар тэжээл, эрдэс тэжээлийн хэмжээ 2006 оныхоос 0.6-4.5 мянган тонноор өсч, байгалийн хадлан 50.2 мянган тонноор буурсан байна.

Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр


МЯН.ТН						
	2003	2004	2005	2006	2007	$\frac{2007}{2006}$ %
Байгалийн хадлан	840.6	850.5	845.1	983.3	933.1	94.9
Сүрэл	22.5	19.2	10.0	4.0	8.5	2.1*
Гар тэжээл	30.5	30.4	35.2	34.0	35.4	104.1
Бэлтгэсэн дарш	3.8	2.1	0.9	0.7	1.3	185.7
Эрдэс тэжээл	42.6	39	44.6	48.5	50.5	104.1
Үйлдвэрлэсэн тэжээл- бүгд, (тэж.нэгж)	465	464.2	468.5	535.9	513.4	95.8

* - дахин их

Тэжээл бэлтгэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжид шилжүүлснээр/ Орхон, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Сэлэнгэ, Хөвсгөл, Дорнод, Баян-Өлгий, Булган зэрэг 9 аймагт 2006 оныхоос 666.3-5231.8 тонноор өсч, бусад аймагт 19.5-7891.4 мянган тонноор буурав (Хавсралт).

Зураг 13

Бэлтгэсэн хадлан



Бүсээр авч үзвэл, тэжээл үйлдвэрлэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжээр / бүх бүсэд 2006 оныхоос 2.1- 43.4 хувиар буюу 0.1-7.9 мянган тонноор буурсан байна.

Нийт бэлтгэсэн тэжээлийн 23.4 хувь нь Баруун, 30.5 хувь нь Хангай, 28.6 хувь нь Төвийн, 15.5 хувь нь Зүүн, 2.0 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Хүснэгт 36

Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамж

	2003	2004	2005	2006	2007
Хонин толгойд шилжүүлсэн мал, мян.тол	46166.6	49070.4	52081.6	57800.0	65037.5
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг м	10.1	9.5	9.0	9.3	7.9

2007 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 7.9 кг тэжээл ногдож байгаа нь 2006 оныхоос 1.4 кг-аар бага байна.

Бэлтгэсэн тэжээлийн хэмжээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан тэжээлийн хэмжээ ороогүй, зөвхөн малчид, аж ахуйн нэгжүүдийн гар аргаар бэлтгэсэн тэжээлийн хэмжээ орсон болно.

Бэлчээр, ургамал хамгаалал. Бэлчээр, бэлчээрийн ургамлыг хамгаалах ажлын хүрээнд Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас (ХХААЯ) 2007 онд нийт 9 аймгийн 81 сумын 421.1 мянга га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготонотой, 5 аймгийн 26 сумын 90.0 мянган га талбайд царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулжээ.

Үлийн цагаан огтонотой тэмцэх ажилд нийт 563.9 сая төгрөг, царцаатай тэмцэх ажилд 401.6 сая төгрөгийг 2007 онд тус тус зарцуулсан байна.

I.2.5 Тэжээвэр амьтад

2007 онд 36.0 мянган гахай, 295.2 мянган шувуу, 926 цаа буга, 324 илжиг, 2393 бүл зөгий тоологдсон нь 2006 оныхоос гахай 3.2, шувуу 83.5 мянгаар, цаа буга 67, тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 37

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо

	2003	2004	2005	2006	2007
Гахай (мян.тол)	13.7	17.2	22.7	32.8	36.0
Шувуу (мян.тол)	90.6	177.4	141.7	211.7	295.2
Цаа буга	612	634	808	859	926
Илжиг	320	402	386	384	324
Зөгий (бүл)	1047	839	789	3404	2393
Туулай	225	257	526	392	371
Гахайтай өрхийн тоо (мян.)	1.8	2	2.3	2.4	2.6
Шувуутай өрхийн тоо(мян.)	1.5	1.7	3.6	1.9	2.1

Тэжээвэр амьтдын дундаас гахай, шувууны аж ахуйг бусад аж ахуйгаас илүүтэйгээр эрхэлж байгаа бөгөөд 2007 онд 2.6 мянган өрх гахай, 2.1 мянган өрх шувуу өсгөн үржүүлж байна.

Өсгөн үржүүлж байгаа гахайны 40.6 хувь нь Төвийн, 25.0 хувь нь Хангайн бүсэд, 29.5 хувь нь Улаанбаатард ногдож байна. Шувууны 70.1 хувь нь Улаанбаатар хотод, 23.2 хувь нь Төвийн бүсэд байна (Хавсралт 44, 45).

2007 онд тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрхүүд 554.6 тонн гахайн мах бэлтгэж, 1142.0 сая төгрөгийн борлуулалт; 113.1 тонн шувууны мах бэлтгэж, 147.7 сая төгрөгийн борлуулалт; 46.2 сая ширхэг өндөг бэлтгэж, 6267.2 сая төгрөгийн борлуулалт; 11.5 тонн зөгийн бал бэлтгэж, 128.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

I.2.6 Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нилээдгүй хөрөнгө, мөнгийг зарцуулж байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

Хүснэгт 38

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо, ам бүл

	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан						1 өрхийн ам бүлийн тоо		
	Өрхийн тоо			Ам бүлийн тоо			2005	2006	2007
	2005	2006	2007	2005	2006	2007			
ДҮН	3811	4513	4752	15738	19275	19639	4.1	4.3	4.1

2007 оны байдлаар улсын хэмжээнд 4752 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4.1 байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 239 өрхөөр буюу 5.3 хувиар нэмэгдсэн байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн 29.0 хувь нь Баруун, 24.6 хувь нь Хангайн, 31.4 хувь нь Төвийн, 13.2 хувь нь Зүүн, 1.8 хувь нь Улаанбаатарт ногдож байна (Хавсралт 46, 47)

Малжуулах арга хэмжээгээр олгогдсон малын тоо

	Малжуулах арга хэмжээгээр олгосон малын тоо, мян.тол			Үүнээс:						Малжуулах арга хэмжээнд хамрагдсан 1 өрхөд ногдох малын тоо, тол		
				Бод малын тоо, мян.тол			Бог малын тоо, мян.тол					
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
ДҮН	114.3	125.9	174.9	6.5	5.4	7.2	107.8	120.4	167.8	30	28	37

Малжуулах арга хэмжээгээр 4.8 мянган өрхөд нийт 174.9 мян.толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 95.9 хувь нь бог мал, 4.1 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 37 толгой мал ногдож байна.

2007 онд малжуулах арга хэмжээнд нийт 5107.7 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүний 16.4 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 6.4 хувь нь орон нутгийн хөрөнгөөр, 77.2 хувь нь бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн тайлан

	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая.төг			Үүнээс:			Нийт зарцуулсан хөрөнгөд эзлэх хувь		
				Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө мян.төг	Орон нутгийн хөрөнгө мян.төг	Бусад мян.төг	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Орон нутгийн төсвийн хөрөнгө	Бусад
	2005	2006	2007						
ДҮН	2 803.0	3 213.3	5107.7	839.3	327.6	3940.8	16.4	6.4	77.2

1.2.7 Шинээр гаргасан, засварласан худаг

Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

2005 оноос эхлэн мал тооллоготой хамтруулан шинээр гаргасан, засварласан худгийн талаархи мэдээллийг цуглуулан авч нэгтгэн гаргаж байна.

2007 онд 1987 худаг шинээр ашиглалтанд орсноос 53.9 хувь буюу 1071 нь энгийн уурхайн, 46.1 хувь буюу 916 нь инженерийн хийцтэй худаг байна.

Шинээр гаргасан худгийн тоо

	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд			Үүнээс:					
				Инженерийн хийцтэй			энгийн уурхайн		
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
Дүн	1492	1516	1987	183	345	916	1309	1171	1071

Шинээр гаргасан худгийн 19.0 хувь нь Баруун, 25.6 хувь нь Хангайн, 24.8 хувь нь Төвийн, 25.6 хувь нь Зүүн бүсэд, 5.1 хувь нь Улаанбаатарт байна (Хавсралт 48)

Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө

	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая төг			Үүнээс:		
				Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
	2005	2006	2007			
Дүн	1279.6	2674.0	7539.8	5856.9	1082.2	600.7

Шинээр худаг гаргахад нийт 7539.9 сая төгрөг зарцуулсны 77.7 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 14.3 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 8.0 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

Хүснэгт 43

Засварласан худгийн тоо

	Засварласан худгийн тоо, бүгд			Үүнээс:					
				инженерийн хийцтэй			энгийн уурхайн		
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
ДҮН	2341	2142	1945	772	933	633	1569	1209	1312

2007 онд нийт 1945 худаг засварласнаас 67.5 хувь буюу 1312 нь энгийн уурхайн, 32.5 хувь буюу 633 нь инженерийн хийцтэй худаг байна.

Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад нийт засварласан худгийн 69.6 хувь буюу 1.4 мянга нь байна

2007 онд засварласан худгийн 14.9 хувь нь Баруун, 19.2 хувь нь Хангайн, 44.9 хувь нь Төвийн, 20.4 хувь нь Зүүн, 0.6 хувь Улаанбаатарт ногдож байна.

Хүснэгт 44

Худаг засварлахад зарцуулсан хөрөнгө

	Худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая төг.			Үүнээс:		
				Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
	2005	2006	2007			
ДҮН	1713.3	2542.3	2366.5	1479.7	453.7	433.1

Худгийн засвар шинэчлэлд нийт 2366.5 сая төгрөг зарцуулсан байна. Нийт зарцуулсан хөрөнгийн 62.5 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 19.2 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 18.3 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

I.3 Мал эмнэлгийн үйлчилгээ

ХХААЯ-ны мэдээгээр 2007 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 24.5 сая толгой мал хамрагдаж, нэг малд 91 төгрөгийн, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21.3 сая толгой мал хамрагдаж, нэг малд 34 төгрөгийн, лабораторийн оношлогоо, шинжилгээнд 786.2 мянган толгой мал хамрагдаж, нэг малд 97 төгрөг, гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад давхардсан тоогоор 5.8 сая толгой мал хамрагдаж, нэг малд 342 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мал эмнэлгийн арга хэмжээний мэдээ

	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ			Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ		
	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг
Дүн	24538.8	2238.3	91	21285.5	249.7	34

үргэлжлэл

	Лабораторийн оношлогоо, шинжилгээ			Гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал		
	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг
Дүн	786.2	76.3	97	5816.0	1990.0	342

2007 онд боом, дуут хавдар, адуун томуу зэрэг халдварт өвчнөөр нийт 35.4 мянган мал өвчилж, 2.7 мянган мал хорогдсон байна. Халдварт өвчнөөр өвчилсөн малын тоо 2006 оныхоос 1.0 мянган толгойгоор буюу 2.8 хувиар өссөн байна.

Мөн паразиттах өвчнөөр 552.8 мянган толгой мал өвчилж, 1.9 мянган толгой мал үхсэн байна. Паразиттах өвчнөөр өвчилсөн малын тоо 2006 оныхоос 77.6 мянгаар толгойгоор буюу 16.3 хувиар нэмэгдсэн байна.

III. ГАЗАР ТАРИАЛАН

III.1 Тариалсан талбай

Тариалсан талбай. Улсын хэмжээгээр 2007 онд нийт 202.7 мян.га-д тариалалт хийсэн нь 2006 оныхоос 40.7 мян.га-аар буюу 25.1 хувиар өсчээ.


Хүснэгт 46

Тариалсан талбай, мян.га-гаар

	2003	2004	2005	2006	2007	2007/2006	
						зөрүү	хувь
Нийт тариалсан талбай	225.9	200.5	189.5	162.0	202.7	40.7	125.1
Үр тариа	207.3	172.9	159.1	126.2	121.8	-4.4	96.5
Үүнээс: Буудай	202.6	168.0	153.8	118.0	116.7	-1.2	98.9
Төмс	8.4	9.1	9.8	10.7	11.5	0.7	106.9
Хүнсний ногоо	5.9	4.9	5.9	5.9	6.1	0.3	104.3
Тэжээлийн ургамал	3.2	5.1	5.2	3.9	4.9	1.1	128.3
Техникийн ургамал	1.1	8.5	9.6	15.3	58.4	43.1	3.8

2007 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: 121.8 мян.га-д үр тариа, 11.5 мян.га-д төмс, 6.1 мян.га-д хүнсний ногоо, 4.9 мян.га-д тэжээлийн ургамал тариалсан нь төмсний тариалсан талбай 2006 оныхоос 6.9 хувь буюу 0.7 мян.га-гаар, хүнсний ногооных 4.3 хувь буюу 0.3 мян.га-гаар, тэжээлийн ургамлынх 28.3 хувь буюу 1.1 мян.га-гаар тус тус өсч, харин үр тарианых 3.5 хувь буюу 4.4 мян.га-гаар буурчээ. (Хүснэгт 49, хавсралт 51)

Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалсан талбай



2007 онд тариалсан талбайн бүтцийг авч үзэхэд 60.1 хувийг үр тарианы, 5.7 хувийг төмсний, 3.0 хувийг хүнсний ногооны, 2.4 хувийг тэжээлийн ургамлын, 28.8 хувийг техникийн ургамлын тариалсан талбай эзэлж байна. Үүнийг 2006 оныхтой харьцуулахад нийт тариалсан талбайд үр тарианы талбайн эзлэх хувь 17.8 пунктээр, төмснийх 0.9 пунктээр, хүнсний ногооных 0.6 пунктээр тус тус буурч, харин техникийн ургамлынх 19.4 пунктээр өссөн байна (Хавсралт 50).

Хүснэгт 47

Тариалсан талбай, аж ахуйн төрлөөр

	Төмс, га	Хүнсний ногоо, га	Тэжээлийн ургамал, га	эзлэх хувь			
				Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал
ХАА-н компани, хоршоо	2501.7	801.7	1861.4	93.8	21.8	13.1	37.7
Иргэд	8959.8	5332.9	3078.0	6.2	78.2	86.9	62.3
Бүгд	11461.5	6134.6	4939.4	100.0	100.0	100.0	100.0

2007 онд тариалалт хийсэн нийт талбайн бүтцийг аж ахуйн нэгжийн төрлөөр нь авч үзвэл ХАА-н компани, хоршоонд үр тарианы талбайн 93.8 хувь, тэжээлийн ургамлын талбайн 37.7 хувь, төмсний талбайн 21.8 хувь, хүнсний ногооны 13.1 хувь нь ногдож байгаа бол иргэд, өрхийн аж ахуйд үр тарианы талбайн 6.2 хувь, төмсний 78.2 хувь, хүнсний ногооны 86.9 хувь, тэжээлийн ургамлын 62.3 хувь нь тус тус ногдож байна (Хүснэгт 47).

Нийт тариалсан талбай Хэнтий, Булган, Дорнод, Дорноговь аймгууд, Улаанбаатар хотод 2006 оноос 4.0-2998.0 га-гаар буурч, бусад аймгуудад 1.0-27199.4 га-гаар нэмэгдсэн байна. Ялангуяа газар тариалангийн гол бүс нутаг болох Сэлэнгэ аймагт 27199.4 га-гаар, Төв аймагт 7267.3 га-гаар, Дархан-Уул аймагт 5035.0 га-гаар, Хөвсгөл аймагт 3146.0 га-гаар, Увс аймагт 1364.9 га-гаар тус тус өссөн байна.

Уринш. 2007 онд 146.8 мян.га талбайд уринш хийсэн нь 2006 оныхоос 12.2 хувиар буюу 25.0 мян.га-гаар их байна. Өмнөх жилүүдэд дунджаар нийт тариалсан талбайн 70.0 хувьд уринш хийж байсан бол 2007 онд тариалсан талбайн 72.4 хувьд уринш хийсэн байна (Хавсралт 53).

Уринш боловсруулалтын нөлөөлөл

ОН	Нийт хураасан үр тариа (мян.тонн)	Тариалсан талбай (мян.га)	Уринш хийсэн талбай (мян.га)	Уринш боловсруулалтын нэг га-д ногдох ургац хураалт (тн)
1993	479.5	584.8	317.9	1.508
1994	330.7	470.6	210.7	1.570
1995	261.4	372.6	245.5	1.065
1996	220.1	347.8	228.0	0.965
1997	240.4	333.8	243.8	0.986
1998	194.9	326.6	232.2	0.839
1999	169.5	296.3	218.8	0.775
2000	142.1	209.3	188.6	0.753
2001	142.2	217.6	274.6	0.518
2002	125.9	285.7	226.8	0.555
2003	165.0	225.9	151.7	1.088
2004	138.5	200.5	144.2	0.960
2005	75.5	189.5	148.7	0.508
2006	138.6	162.0	120.1	1.154
2007	114.8	202.7	146.8	0.782

III.2 Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац

Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 172.7 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 147.1 тэрбум төгрөгт хүрч, 2006 онтой харьцуулахад оны үнээр 17.2 хувиар, зэрэгцүүлэх үнээр 3.1 хувиар тус тус өслөө (Хүснэгт 49).

Хүснэгт 49

Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт

сая төг.	2006	2007	2007/2006	
			%	зөрүү
			Оны үнээр	147333.2
2005 оны зэрэгцүүлэх үнээр	142775.1	147132.7	103.1	4357.6

Хураасан ургац. 2007 онд 114.8 мян.тн үр тариа, 114.5 мян.тн төмс, 76.4 мян.тн хүнсний ногоо хурааж, 933.1 мян.тн өвс хадлан, 35.4 мян.тн гар тэжээл бэлтгэсэн нь 2006 оныхоос төмс 5.4 мян.тн-оор буюу 5.0 хувиар, хүнсний ногоо 6.0 мян.тн-оор буюу 8.6 хувиар, гар тэжээл 1.4 мян.тн-оор буюу 4.2 хувиар тус тус өсч, харин үр тариа 23.8 мян.тн-оор буюу 17.2 хувиар, өвс хадлан 50.2 мян.тн-оор буюу 5.1 хувиар буурсан байна. (Хүснэгт 50, хавсралт 50).

Хүснэгт 50


Хураасан ургац

	Хураасан ургац, мян.тн					2007/2006	
	2003	2004	2005	2006	2007	хувь	зөрүү
Үр тариа	165.0	138.5	75.5	138.6	114.8	82.8	-23.8
Үүнээс: Буудай	160.4	135.6	73.4	127.8	109.6	85.8	-18.2
Төмс	78.7	80.2	82.8	109.1	114.5	105.0	5.4
Хүнсний ногоо	59.6	49.2	64.2	70.4	76.4	108.5	6.0
Хадлан	840.7	850.5	845.1	983.3	933.1	94.9	-50.2
Тэжээлийн ургамал	8.4	9.6	8.3	10.2	14.1	138.2	3.9

2007 онд хураан авсан ургацыг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулбал үр тариа 11.3 хувь буюу 14.6 мян.тн-оор, тэжээлийн ургамал 11.0 хувиар буюу 1.0 мян.тн-оор буурч, харин төмс 30.6 хувиар буюу 26.8 мян.тн-оор, хүнсний ногоо 25.5 хувь буюу 15.5 мян.тн-оор, хадлан бэлтгэлт 6.0 хувиар буюу 53.2 мян.тн-оор тус тус өссөн байна.

Зураг 15

Хураасан ургац



2007 онд аж ахуйн нэгж, байгууллага үр тарианы 95.3 хувь, төмсний 20.3 хувь, хүнсний ногооны 12.6 хувийг тус тус үйлдвэрлэсэн бол иргэд, өрхийн аж ахуй үр тарианы 4.7 хувь, төмсний 79.7 хувь, хүнсний ногооны 87.4 хувийг тус тус үйлдвэрлэсэн байна (Хүснэгт 51).

Хүснэгт 51

Хураасан ургац, аж ахуйн төрлөөр

	Хураасан ургац, тн				Эзлэх хувь			
	Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал
ХАА-н компани, хоршоо	109358.4	23282.3	9657.9	9181.9	95.3	20.3	12.6	65.1
Иргэд, өрхийн аж ахуй	5419.8	91208.1	66772.6	4927.8	4.7	79.7	87.4	34.9
Бүгд	114778.2	114490.4	76430.5	14109.7	100.0	100.0	100.0	100.0

2007 онд үр тариа хураалт Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Хөвсгөл аймгуудад 2006 оныхоос 0.1-3960.1 тн-оор нэмэгдэж, бусад бүх аймагт 156.1-7950.7 тн-оор буурсан байна. Төмс хураалтын хувьд Архангай, Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар, Орхон аймагт 4.7-619.3 тн-оор буурч, харин бусад аймгуудад 4.9-1875.9 тн-оор өссөн байна.

Манай оронд хүчит буудайн “Орхон” сорт, зусах буудайн “Дархан-34”, “Дархан-74” сорт, зусах буудайн “Халх гол-1” сорт, мөн усалгаатай улаан буудайн “Юнцо”, “Цагаан дэглий” сортуудыг тариалж байна.

Төмс нь хураан авч буй ургацын хэмжээ болон ач холбогдлоороо буудайн дараа ордог газар тариалангийн гол бүтээгдэхүүн юм. “Монгол төмс” хөтөлбөрөөс сүүлийн жилүүдэд явуулж байгаа судалгааны үр дүнгээр голландын эрт болцтой “Импала” сорт, германы дунд эртийн болцтой “Витара” сортыг нутагшсан сортоор, голландын дунд эртийн болцтой “Санте” сортыг Улсын сорт сорилтын зөвлөл ашиглахаар баталсан байна. Эдгээр сортыг тариалангийн гол бүс нутгуудад 200.0 гаруй га талбайд тариалж, тодорхой хэмжээний үрийн нөөцтэй болоод байна.

Хүнсний ногооны хувьд Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Увс, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймгууд болон Улаанбаатар хотод 3.7-1740.7 тн-оор буурч, бусад аймгуудад 15.6-5032.5 тн-оор өссөн байна (Хавсралт 1, 3).

Техникийн ургамлын хувьд 2007 онд Сэлэнгэ, Төв, Дархан, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Орхон аймгууд тосны ургамал, рапсийг 17.2 мян. тн-ыг хураан авсан нь 2006 оныхоос 1.6 дахин буюу 6.2 мян.тн-оор илүү байна.

Ургац хураалтад нөлөөлсөн хүчин зүйл. 2007 онд тариалсан талбайн хэмжээ өмнөх жилүүдээс буурсан боловч нэг га-аас авсан ургацын хэмжээ сүүлийн 4 жилийн дунджаас нэлээд өссөн байна. Хураан авсан үр тарианы ургацын хэмжээнд нөлөөлсөн тариалсан талбайн болон га-гийн ургацын хүчин зүйлийн нөлөөллийг судалж үзэхэд 2007 онд тариалсан талбайн хэмжээ өмнөх оноос 4.4 мян.га-аар багассанаас 4857.3 тн үр тариа, га-гийн ургац 0.2 цн-ээр буурснаас 18.9 мянган тонн үр тариа хурааж авах боломж алдсан байна. Харин хураасан төмсний хувьд тариалсан талбайн хэмжээ 0.7 мянган га-гаар нэмэгдсэнээс 8.4 мянган тонн төмс өмнөх оноос илүү хураасан бол га-гийн ургацын хэмжээ 10.1 цн-ээр буурснаас 2.9 мянган тонн төмс хураах боломжийг алдсан байна (Хүснэгт 52).

Хүснэгт 52

2007 оны ургацад нөлөөлсөн зарим хүчин зүйл

Хүчин зүйлийн нөлөөлөл		Аймгийн нэр	Ургацын хэмжээ (тн)
Нийт ургацыг нэмэгдүүлсэн			
Талбайн хэмжээ, га-гийн ургац нэмэгдсэнээс	үр тариа	ГО, УВ, ХӨ	4420.3
	төмс	БХ, БУ,ГО, ЗА, ӨВ, ӨМ, СЭ, ХО	5358.8
Га-гийн ургац буурсан боловч талбайн хэмжээ нэмэгдсэнээс	үр тариа	БХ	3.5
	төмс	ДУ, ТӨ	1723.7
Талбайн хэмжээ буурсан боловч Га-гийн ургац нэмэгдсэнээс	үр тариа	БӨ	0.1
	төмс	ДД, ДА, ГС	540.5
Нийт ургацыг бууруулсан			
Талбайн хэмжээ, га-гийн ургац зэрэг буурснаас	үр тариа	ДД, ӨВ, ТӨ, ХО, ХЭ, ДА	16060.2
	төмс	БӨ, ДО, ХЭ, УБ	955
Талбайн хэмжээ нэмэгдсэн ч га-гийн ургац буурснаас	үр тариа	АР, СЭ, ОР	9138.8
	төмс	СҮ, УВ, ХӨ, ОР	805.9
Га-гийн ургац өссөн ч талбайн хэмжээ буурснаас	үр тариа	БУ	3018.7
	төмс	АР	421.9

Дээрх хүснэгтээс үзэхэд нэг га-аас авах ургац болон талбайн өсөлт, бууралтын нөлөөллөөр хураасан үр тариагаа 2006 оныхоос Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Хөвсгөл аймгууд нийлбэр дүнгээр 4423.9 тн-оор нэмэгдүүлж, харин Архангай, Булган, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, Дархан, Орхон аймгууд нийтдээ 28217.7 тн-оор бууруулсан байна.

Харин төмсний хувьд нэг га-аас авах ургац болон талбайн өсөлт, бууралтын нөлөөллөөр төмсний ургац хураалтыг Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд, Дархан-Уул, Говьсүмбэр аймгууд 2006 оныхоос нийлбэр дүнгээр 7623.0 тн-оор нэмэгдүүлж, харин Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар, Орхон аймгууд 2182.8 тн-оор бууруулсан байна.

Дотоодын үйлдвэрт боловсруулсан газар тариалангийн бүтээгдэхүүн. 2007 оны намрын ургацаас Алтантариа, Улаанбаатар гурил, Дарханы гурилын үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүд 53.0 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих сан 11.1 мянган тонн, бусад жижиг гурил үйлдвэрлэгчид 10.1 мянган тонн, нийтдээ 74.2 мянган тонн буудай худалдан авч, 60.0 гаруй мянган тонн гурил үйлдвэрлэсэн нь дотоодын үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн гурилын 84.7 хувийг эзэлж байна.

Дотоодын үйлдвэрт боловсруулсан бүтээгдэхүүн

	Х/н	2006	2007	2007/2006	
				%	зөрүү
Үр тарианы гурил	мян.тн	63.5	70.8	111.5	7.3
Үүнээс: -дээд гурил	мян.тн	18.2	22.4	123.1	4.2
-1-р гурил	мян.тн	36.2	36.1	99.7	-0.1
-2-р гурил	мян.тн	7.1	12.3	173.2	5.2
-3-р гурил	мян.тн	1.9	-	-	-
Тэжээл	мян.тн	24.9	22.3	89.6	-2.6

Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Үндэсний Статистикийн газрын албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн хэрэглээг тооцож үзэхэд 2007 онд улсын хэмжээгээр 210.4 мян.тн улаан буудай, 105.1 мян.тн хүнсний ногоо, 144.7 мян.тн төмс зах зээлд нийлүүлэгдсэнээс улаан буудайн 52.1 хувь, хүнсний ногооны 72.8 хувь, төмсний 79.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдсэн хувийг импортоор хангасан байна. Харин дотоодын үйлдвэрлэгчдийн нийт үйлдвэрлэлт 2006 оныхоос улаан буудайных 18.2 мян.тн-оор буурч, харин төмснийх 5.4 мян.тн-оор, хүнсний ногооных 6.1 мян.тн-оор тус тус нэмэгдсэн байна. (Хавсралт 54). Улаан буудайны хэрэглээнд дотоод үйлдвэрлэлийн хувийн жин 3.5 пунктээр, хүнсний ногооных 3.2 пунктээр тус тус 2006 оныхоос буурч, харин төмсний нийт хэрэглээнд эзлэх дотоодын үйлдвэрлэлтийн хувийн жин 3.7 пунктээр 2006 оныхоос өссөн байна.

Хүснэгт 54

Үйлдвэрлэл, хэрэглээний харьцаа

	Нийт хэрэглээ, (мян.тн) (дотоодын үйлдвэрлэл+импорт)				Дотоодын үйлдвэрлэл, мян.тн				Дотоодын үйлдвэрлэлт/нийт хэрэглээ (%)			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Төмс	118.6	123.8	144.7	144.7	80.2	82.8	109.1	114.5	67.6	66.9	75.4	79.1
Хүнсний ногоо	74.5	87.1	92.8	105.1	49.2	64.1	70.4	76.5	66.0	73.6	75.9	72.7
Улаан буудай	250.5	171.0	230.0	210.4	135.6	73.4	127.8	109.6	54.1	43.0	55.6	52.1

2007 онд манай улсад 100.8 мян.тн улаан буудайн гурил импортоор орж ирсний 74.3 хувийг ОХУ-аас, 14.6 хувийг БНХАУ-аас, 11.0 хувийг Казакстан улсаас авсан байна. Өмнөх онтой харьцуулахад Казакстан улсаас оруулж ирсэн улаан буудайн гурилын эзлэх хувь 9.7 пунктээр буурч, ОХУ болон БНХАУ-аас оруулж ирсэн гурилын эзлэх хувь 2.3-7.9 пунктээр өсчээ.

Хүснэгт 55

Импортыг үйлдвэрлэл, хэрэглээтэй харьцуулсан байдал

	Үйлдвэрлэл/хэрэглээ				Импорт/хэрэглээ				Импорт/үйлдвэрлэл			
	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007	2004	2005	2006	2007
Төмс	67.6	66.9	75.4	79.1	32.4	33.1	24.6	20.9	47.9	49.5	32.6	26.4
Хүнсний ногоо	66.0	73.6	75.9	72.7	34.0	26.4	24.1	27.3	51.5	35.9	31.7	37.4
Улаан буудай	54.1	43.0	55.6	52.1	45.9	57.0	44.4	47.9	84.7	132.6	80.0	92.0

Гаалийн Ерөнхий Газрын статистик мэдээгээр манай улс 2007 онд импортоор 100.8 мян.тн улаан буудай, 30.2 мян.тн төмс, 28.6 мян.тн хүнсний ногоо авсан нь өмнөх оныхоос улаан буудайн импорт 1.4 мян.тн-оор, төмсний импорт 5.4 мян.тн-оор тус тус буурч, харин хүнсний ногооны импорт 9.8 мян.тн-оор өссөн байна.

2007 онд импортолсон 100.8 мян.тн улаан буудай нь манай улсын улаан буудайн хэрэглээний 52.1 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх оноос 3.5 пунктээр буурчээ.

III.3 ГА-ГИЙН УРГАЦ

2007 онд нэг га-аас дунджаар 9.4 цн үр тариа, үүнээс 9.4 цн буудай, 13.8 цн арвай, 8.4 цн овъёос, 99.9 цн төмс, 16.3 цн тэжээлийн ургамал хураан авсан бөгөөд нэг га-гаас авсан ургац хүнсний ногооноос төрөл дээрээ буурсан байна (Хүснэгт 55).

2006 оныхоос нэг га-аас авсан ургац үр тарианых 1.6 цн, буудайных 1.4 цн, арвайнх 22.5 цн, овъёосных 6.4 цн, төмснийх 1.8 цн-ээр тус тус буурсан байна.

Хүснэгт 56

Га-гийн ургац

Төрөл	центнер				
	2003	2004	2005	2006	2007
Үр тариа-дундаж	8.0	8.0	4.7	11.0	9.4
Улаан буудай	7.9	8.1	4.8	10.8	9.4
Арвай	12.5	6.1	6.0	36.3	13.8
Овъёос	11.4	6.8	6.9	14.8	8.4
Төмс	93.4	88.3	84.8	101.7	99.9
Хүнсний ногоо	101.6	99.9	108.9	119.7	124.6
Тэжээлийн ургамал	26.0	18.8	16.1	28.8	28.6

Манай улсын түүхэнд 1985 онд хамгийн их үр тариа хурааж байх үед га-гаас 13.9 цн үр тариа авч байв. Түүнчлэн 1989 онд хамгийн их талбайд тариалалт хийсэн байна. 2007 оны хувьд хүнсний ногооны хураан авсан ургац түүхэнд хамгийн их байлаа (Хүснэгт 56).

Хүснэгт 57

Хураасан ургац, тариалсан талбай, га-гийн ургацын дээд хэмжээ

	Хураасан ургац		Тариалсан талбай		Га-гийн ургац	
	он	мян.тн	он	мян.га	он	цн
Үр тариа	1985	886.2	1989	673.4	1985	13.9
Үүнээс: Буудай	1985	688.5	1990	532.9	1985	14.3
Төмс	1989	155.5	1988	13.1	1984	130.0
Хүнсний ногоо	2007	76.4	2007	6.1	-	-
Тэжээлийн ургамал	1987	607.9	1988	169.5	-	-
Хадлан	1958	1781.0	-	-	-	-

2007 онд га-гаас хураан авсан үр тариа Баян-Өлгий, Булган, Төв, Хөвсгөл аймгуудад 0.3-4.1 цн-ээр өсч, харин бусад аймгуудад 0.4-9.9 цн-ээр буурсан байна.

Га-гаас хураан авсан төмс Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан, Говьсүмбэр аймгуудад 0.7-18.3 цн-ээр өсч, бусад аймгуудад 1.6-111.9 цн-ээр буурчээ. (Хавсралт 52).

Өнгөрсөн 7 сард тариалангийн бүс нутгуудаар 10-14 хоног үргэлжилсэн нарны хэт их халалт болсон нь таримал ургамлын ургацад муугаар нөлөөлж, улмаар хураасан ургацын хэмжээ, га-гаас авах ургацын хэмжээ буурахад зохих нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 58

Га-аас хураасан төмс, хүнсний ногооны ургац, аж ахуйн төрлөөр

	Нийт			ХАА-н компани			Иргэд, өрхийн аж ахуй		
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
Үр тариа	4.7	11.0	9.4	4.7	11.2	9.5	4.8	8.3	7.1
Төмс	84.8	101.7	99.9	76.7	85.4	93.1	87.6	105.8	101.8

Га-гаас авч байгаа үр тариа, төмсний хэмжээг хөрш орнуудтай харьцуулж үзэхэд ОХУ-д 2006 оны байдлаар га-гаас 18.9 цн үр тариа, Хятад улсад 2005 оны байдлаар 52.3 цн үр тариа, Өвөр Монголд 49.1 цн үр тариа хурааж авсан байна.

III.4 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР

Газрын харилцаа, геодези зураг, зүйн газрын мэдээгээр 2007 онд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 116.0 сая га-д хүрч, 2006 оныхоос 44.8 мян. га-гаар буурсан байна. Үүний дотор бэлчээрийн талбай 49.2 мян.га-гаар буурч, харин хадлангийн талбай 1.6 мян.га, тариалангийн талбай 6.7 мян.га-гаар өссөн байна.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 96.3 хувийг бэлчээрийн талбай, 1.6 хувийг хадлангийн талбай, 0.6 хувийг тариалангийн талбай, 1.5 хувийг бусад газар эзэлж байна (Хүснэгт 58).

Хүснэгт 59

ХАА-н эдэлбэр газар

	2003	2004	2005	2006	2007	мян.га
						2007 % 2006
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	115580.5	115455.7	115232.6	116037.6	115992.8	99.96
Үүнээс: - Бэлчээр	111280.8	111146.9	110929.6	111729.0	111679.8	99.96
- Хадлан	1809.1	1828.9	1822.8	1821.4	1823	100.1
- Тариалан	705.7	705.7	697	697.8	704.5	101.0
- Атаржсан газар	475.8	471.2	478.4	479.5	472.5	98.5
- ХАА-н бусад .						
- хэрэгцээний газар	42.2	41.5	43.3	48.4	51.4	106.2
- ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1266.9	1261.4	1261.4	1261.6	1261.6	100.0

Бэлчээрийн газар нь 2006 оны тайлантай харьцуулахад 49.2 мянган га-гаар буурсан байна. Энэ нь уурхайн эдэлбэр газар нэмэгдэж байгаа, шинээр өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшилд олгож байгаа, хадлангийн зориулалтаар эзэмшилд олгосон, атар газар хагалсан болон зарим хот, тосгон бусад суурины газарт иргэдэд газар өмчлүүлэхтэй холбогдуулан тэг гортигоо тэлж байгаатай холбоотойгоор гарсан өөрчлөлт юм.

Хадлангийн газрын хувьд өнгөрсөн оны тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад 1.6 мянган га-гаар нэмэгджээ. Малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн ургац муудаж байгаатай холбоотойгоор нэмэлт хадлангийн талбай ашиглах, усалж тордох, бордох боломж бүхий талбайнуудыг хашиж хамгаалан байнгын хадлангийн талбайтай болж байгаагаас Хөвсгөл, Баян-Өлгий, Увс зэрэг аймгуудад хадлангийн газрыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшилд олгосноор хадлангийн талбайн хэмжээ бэлчээрийн газраас нэмэгдсэн дүнтэй байна.

Тариалангийн газар нь урьд онтой харьцуулахад нийт дүндээ 6.7 мянган га-гаар нэмэгдсэн байна. Улаанбаатар, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай зэрэг аймгуудад атаршсан газраас эргүүлэн тариалангийн зориулалтаар ашиглахаар эзэмшилд олгосноос тариалангийн газар нэмэгджээ.

Атаршсан газрын хэмжээг 2006 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 7.0 мянгаар буурсан байна. Нийслэл болон Хөвсгөл аймагт 482.3 га тариалангийн газар олон жил тариалалт хийгдээгүй орхигдсоны улмаас эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийг цуцалж, атаршсан газарт шилжүүлэх өөрчлөлт хийгдсэн боловч Улаанбаатар, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Баян-Өлгий зэрэг аймгуудад атаршсан газрыг тариаланд ашиглахаар эзэмшилд олгосон, Сэлэнгэ аймагт тариалан, атаршсан газрын кадастрын зураглал, бүртгэл хийсэн үр дүнгээс шалтгаалан атаршсан газрын хэмжээ өнгөрсөн оныхоос буурсан дүнтэй байна.

IV. Мал бүхий өрхийн нэг удаагийн түүвэр судалгааны дүн

Үндэсний статистикийн хороо нь өөрийн чиг үүргийнхээ хүрээнд хөдөө аж ахуйн статистикийг боловсронгуй болгох, мэдээлэл цуглуулах түүвэр судалгааны аргыг уг салбарт нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, салбарын бодлого, тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бий болгох чиглэлээр багагүй ажлыг хийж гүйцэтгэж байна.

Цаашид ҮСХ-оос зөвхөн малын тоо, толгойтой холбоотой мэдээллийг цуглуулаад зогсохгүй мал ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй мал бүхий өрхийн мал аж ахуйгаас олж буй орлого, гарч буй зардал зэрэг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болон малын тооны зохист харьцаа, өрхийн амьжиргааг хангах боломжит малын тоо, малчдад хүрч буй нийгмийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлон тогтоож, судалгаанд хамруулах зорилтыг тавьж байгаа бөгөөд эдгээр мэдээллийг эхний удаад туршилтын байдлаар цуглуулах зорилгоор 2007 оны жилийн эцсийн мал тооллоготой хамтруулан нэг удаагийн судалгааг явууллаа. Энэ судалгааны дүнгээс энэхүү танилцуулгад мөн тусгаж байгаа болно.

Мал аж ахуйгаас олсон орлого, бүтээгдэхүүний төрлөөр. Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан нэг өрх мал аж ахуйгаас жилд дунджаар нийтдээ 4.7 сая төгрөгийн орлого олсон бөгөөд үүний 57.5 хувь буюу 2.7 сая төгрөгийг мал, махнаас, 1.4 хувь буюу 63.6 мянган төгрөгийг сүүнээс, 36.2 хувийг буюу 1.7 сая төгрөгийг ноос, ноолуураас, 4.9 хувь буюу 232.2 мянган төгрөгийг арьс шир худалдаж борлуулснаас олсон байна.

Эндээс мал аж ахуйн орлого нь үндсэндээ мал, мах, ноос, ноолуур худалдан борлуулсан орлогоос бүрдэж (93.7 хувь) байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 60

Мал аж ахуйгаас олсон орлого, бүтээгдэхүүний төрлөөр.

	Нийт орлого	Үүнээс:			
		Мал, мах	Сүү	Ноос, ноолуур, хөөвөр, хялгас	Арьс, шир
1 өрхөд ногдох орлого, мян.төг	4709.6	2709.3	63.6	1704.4	232.2
Нийт орлогод эзлэх хувь	100.0	57.5	1.4	36.2	4.9

Мал аж ахуйгаас олсон орлого, аж ахуйн төрлөөр. Судалгааны дүнгээр мал аж ахуйг эрхэлж буй нэг өрх жилд дунджаар тэмээний аж ахуйгаас 114.1 мянга, адууны аж ахуйгаас 444.8 мянга, үхрийн аж ахуйгаас 787.0 мянга, хонины аж ахуйгаас 1280.1 мянга, ямааны аж ахуйгаас 2083.6 мянган төгрөгийг тус тус олсон байна.

Нийт орлогын 44.2 хувийг ямааны аж ахуй, 27.2 хувийг хонины аж ахуй, 16.7 хувийг үхрийн аж ахуй, 9.4 хувийг адууны аж ахуй, 2.4 хувийг тэмээний аж ахуй бүрдүүлж байна.

Хүснэгт 61

Мал аж ахуйгаас олсон орлого, аж ахуйн төрлөөр

Мал аж ахуйгаас олсон орлого, аж ахуйн төрлөөр	Нийт орлого	Үүнээс:				
		Тэмээний аж ахуй	Адууны аж ахуй	Үхрийн аж ахуй	Хонины аж ахуй	Ямааны аж ахуй
1 өрхөд ногдох орлого, мян.төг	4709.6	114.1	444.8	787.0	1280.1	2083.6
Нийт орлогод эзлэх хувь	100.0	2.4	9.4	16.7	27.2	44.2

Бусад орлого. Мал бүхий өрхийн мал аж ахуйгаас гадна олж орлогыг талаархи мэдээллийг мөн энэ судалгаагаар цуглуулсан.

Бусад орлого

	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	Хүүхдийн мөнгө	МАН-аас бусад худалдаа, үйлчилгээний орлого	Машин, техникийн түрээс	Бусад	Дүн
1 өрхөд ногдох орлого, мян.төг	215.8	295	164.7	45.5	7.5	0.4	729
Дүнд эзлэх хувь	29.6	40.5	22.6	6.2	1.0	0.1	100.0

Судалгаагаар нэг өрх жилд дунджаар 729.0 мянган төгрөгийн бусад орлогын олсон бөгөөд үүний 29.6 хувь буюу 215.8 мянга нь цалин хөлснөөс, 40.5 хувь буюу 295.1 мянга нь тэтгэвэр, тэтгэмжээс, 22.6 хувь буюу 164.7 мянга нь хүүхдийн мөнгөнөөс, 6.2 хувь буюу 45.5 мянга нь мал аж ахуйгаас олсон бусад худалдаа, үйлчилгээний орлогоос, 1.0 хувь буюу 7.5 мянгыг машин техникийн түрээсээс, 0.1 хувь буюу 0.4 мянгыг бусад орлогоос олсон байна.

Хүнсэнд хэрэглэсэн мал. Судалгааны дүнгээр нэг өрх жилд дунджаар 23 толгой малыг хүнсэнд хэрэглэсний 2 толгой нь бод, 21 толгой нь бог мал байна. Нийт хүнсэнд хэрэглэсэн малын 8.8 хувь нь өсвөр мал, 91.2 хувь нь нас гүйцсэн мал байна.

Зах зээлд борлуулсан мал. Судалгаанд хамрагдсан нэг өрх жилд дунджаар 28 толгой малын зах зээлд борлуулснаас төл мал 1, өсвөр мал 3, нас гүйцсэн мал 24 толгой байна.

Хүнсэнд хэрэглэсэн болон зах зээлд борлуулсан малын 84.4-91.2 хувь нь нас гүйцсэн мал байна.

Өрхийн амьжиргааг боломжит байдлаар хангах малын тоо. Судалгаанд хамрагдсан нийт өрхөөс тухайн өрхийн амьжиргааг хангах малын тоо хэд байвал тохиромжтой байх талаархи саналыг асуусан. Одоогийн байдлаар нэг өрхөд дунджаар нийт 568 толгой мал, үүнээс тэмээ 16, адуу 40, үхэр 36, хонь 260, ямаа 216 толгой байвал тохиромжтой байна гэсэн хариулт өгсөн байна.

Хүснэгт 63

Өрхийн амьжиргааг боломжит байдлаар хангах малын тоо

	Дүн	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1 өрхөд ногдох мал	568	16	40	36	260	216

Одоогийн байдлаар мал тооллогын дүнгээр мал бүхий 1 өрхөд дунджаар нийт 154 толгой мал, үүнээс тэмээ 1, адуу 9, үхэр 10, хонь 66, ямаа 69 толгой тус тус ногдож байна.

Малын сүргийн бүтцийн зохист харьцаа. Мөн судалгаанд хамрагдсан өрхөөс мал сүргийн бүтцийн зохист харьцааны талаар асуухад нийт сүргийн 6.5 хувийг тэмээ, 10.1 хувийг адуу, 12.3 хувийг үхэр, 41.3 хувийг хонь, 29.8 хувийг ямаа эзэлж байвал зохимжтой байна гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 64

Мал сүргийн бүтцийн зохист харьцаа, хувиар

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүнд эзлэх хувь	100.0	6.5	10.1	12.3	41.3	29.8

Судалгаанд хамрагдсан мал бүхий өрх нь нийт сүрэгт бод малыг 30 хувь, бог малыг 70 хувь байхаар хариулт өгсөн байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулж буй байдал. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 18.4 хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө аваачиж

борлуулдаг, 35.7 хувь нь зах зээлд өөрсдөө борлуулах, түүхий эдийг ченжид борлуулах хоёрыг аль алийг нь хослуулдаг, 45.9 хувь нь шууд түүхий эдийн ченжид борлуулдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 65

**Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнийг
борлуулж буй байдал**

	Мал	Мах	Ноос, ноолуур, хөөвөр	Арьс шир
Зах зээлд өөрсдөө очиж борлуулдаг	19.9	28.9	35.0	38.3
Зах зээлд өөрсдөө борлуулдаг болон наймаачдад өгдөг	5.1	4.0	3.2	4.7
Түүхий эдийн наймаачдад шууд өгдөг	75.1	67.1	61.7	57.0

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй нийт өрхийн 57.0-75.1 хувь нь мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, ноос, ноолуур, арьс, ширийг түүхий эдийн наймаачинд борлуулсан байна.

Эндээс харахад мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үндсэндээ түүхий эдийн наймаачдад дамжигдан, зах зээлд хүрч байгаа нь энэ хооронд тодорхой хэмжээний үнийн нэмэгдэл бий болох гол шалтгаан болж байна.

Өрхийн хүнсний ба хүнсний бус барааг худалдан авч буй байдал. Судалгаагаар тухайн өрхийн хүнсний ба хүнсний бус барааны хэрэгцээгээ хангахдаа бэлэн мөнгө, мал аж ахуйн бүтээгдэхүүний ямар хэлбэрээр голчлон арилжиж байгааг тогтоохыг зорьсон.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 92.4 хувь нь хүнсний бараагаа бэлэн мөнгөөр, 7.6 хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүн, бэлэн мөнгийг хослуулан арилждаг байна. Харин 89.5 хувь нь хүнсний бус бараагаа бэлэн мөнгөөр, 10.5 хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүн, бэлэн мөнгөөр хослуулан сольж, арилжсан байна.

Эндээс харахад малчин өрх хүнсний болон хүнсний бус барааны хэрэгцээгээ ихэвчлэн бэлэн мөнгөөр худалдан авсан байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүд хүнсний болон хүнсний бус бараагаа худалдаж авахдаа ихэвчлэн мал, ноос, ноолуур, арьс ширээр сольж арилжжээ.

Хүснэгт 66

**Өрхийн хүнсний ба хүнсний бус барааг
худалдан авч буй байдал**

	Мал аж ахуйн бүтээгдэхүүн, бэлэн мөнгөөр	Бэлэн мөнгөөр
Хүнсний бараа	7.6	92.4
Хүнсний бус бараа	10.5	89.5

Мал эмнэлгийн үйлчилгээ. Судалгаанд хамрагдсан өрхүүд нь тарилга, туулга, угаалга үйлчилгээнд голлон хамрагдсан байна. Тарилгын үйлчилгээнд нэг өрх нэг малыг жилд дунджаар 2 удаа, 85 төгрөгийн үнэтэйгээр, туулгын үйлчилгээнд 1.2 удаа, 60 төгрөгөөр, угаалгын үйлчилгээнд 1 удаа, 95 төгрөгийн үнэтэйгээр хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан өрхийн 91.0 хувь нь тарилга, 54.5 хувь нь туулга, 32.5 хувь нь угаалгын үйлчилгээнд хамрагдсан байна.

Банк санхүүгийн үйлчилгээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 35.7 хувь банкны зээлийн үйлчилгээнд хамрагдсан байна.

Нэг өрх дунджаар 2338.2 мянган төгрөгийн зээлийг 9.3 сарын хугацаатайгаар, сарын 3.2 хувийн хүүтэйгээр авсан байна.

Зээлийн барьцаанд мал, гэр, байшин, машин, үнэт эдлэл, тэтгэвэр, тэтгэмжээ тавьсан бөгөөд өрхийн 71.2 хувь нь мал, үлдсэн 28.8 хувь нь гэр, байшин, мотоцикль, өвөлжөө бууц, үнэт эдлэлээ зээлийн барьцаанд тавьсан байна.

Зээлийг мал, өвс тэжээл худалдаж авах, хурдны морь, машин, гэр байшин, малыг үүлдрийг сайжруулах, эмчилгээ хийлгэх, оюутны сургалтын төлбөр төлөх, хувийн бусад хэрэгцээ хангахад зориулан авсан байна. Авсан зээлийн 14.4 хувийн мал худалдаж авах, үүлдэр угсааг сайжруулахад, 17.3 хувийг оюутны сургалтын төлбөрт, үлдсэн 68.3 хувийг машин, мотоцикль, хашаа байшин, худалдаж авах болон хувийн хэрэгцээгээ хангахад тус тус зориулсан байна.

Банкны зээлийн үйлчилгээнд хамрагдсан байдал

	Зээлийн хэмжээ, мян.төг	Хугацаа, сараар	Сарын хүү, хувиар	Барьцаа	Зориулалт
1 өрхөд ногдох	2338.2	9.3	3.2	Мал, машин, гэр байшин, тэтгэвэр, үнэт эдлэл	Мал худалдаж авах, сургалтын төлбөр, хашаа, байшин гэр авах, хувийн хэрэгцээгээ хангах

Даатгалын үйлчилгээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 27.8 хувь нь нийгмийн даатгал, 87.0 хувь нь эрүүл мэндийн даатгалд тус тус хамрагдсан байна.

Харин судалгаанд хамрагдсан өрхийн 12.3 хувь нь арилжааны даатгалд хамрагдсны дөнгөж 1.1 хувь нь мал, 1.8 хувь нь хашаа, бууц, 10.1 хувь нь гэр, байшин гэх мэт бусад хөрөнгөө даатгуулсан байна.

Судалгааны дүнгээс харахад сүүлийн жилүүдэд мал бүхий өрхүүд мал аж ахуйн үйлдвэрлэлээс нилээдгүй хэмжээний орлогыг олж, үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлд чөлөөтэй оролцох боломжтой болсон байна. Гэхдээ ихэвчлэн түүхий эдийн шинж чанартай мал, ноос, арьс, шир гэх мэт бүтээгдэхүүнийг өөрсдөө зах зээлд борлуулах эсвэл түүхий эдийн наймаачдаар дамжуулан зах зээлд борлуулах замаар орлого олж байна. Гэтэл сүү, цагаан, идээ зэрэг бусад бүтээгдэхүүнийг хадгалалтын байдал, зах зээл алслагдмал байдлаас шалтгаалан зөвхөн өрхийн хэрэгцээг хангах төдийгөөр л ашиглаж байна. Иймд цаашид дээрхи байдлыг харгалзан мал аж ахуйн бүтээгдэхүүнийг малчдаас худалдан авах, хадгалах түүхий эдийн төвлөрсөн цэг бий болгох, хот суурин газруудад сүү, цагаан идээ боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулах зэрэг асуудалд анхаарах шаардлагатай байна.

Цаашид бид мал аж ахуйн салбарт шаардлагатай байгаа мэдээллийн талаар холбогдох яам, газруудын саналыг авч, уг туршилтын судалгааг өргөжүүлэн, сайжруулах болно.

ДҮГНЭЛТ

2007 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 40.3 сая толгойд хүрч, 2006 оныхоос 5.5 саяар буюу 15.7 хувиар, малын таван төрөл дээрээ өслөө.

Малын тоо толгой өсөхөд байгаль, цаг уур тааламжтай байдал, бойжуулсан төлийн тоо 2006 оныхоос 1989.0 мянган толгойгоор нэмэгдсэн, зүй бус хорогдол 182.2 мянган толгойгоор буурсан нь голлон нөлөөлжээ.

Малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 53.0 хувийг ямаа, 39.8 хувийг хонь, 4.7 хувийг үхэр, 2.3 хувийг адуу, 0.1 хувийг тэмээний өсөлт хангасан байна.

Малын тоо, толгой өссөнөөр мал аж ахуйн салбарт ахиц гарч, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1147.0 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 919.9 тэрбум төгрөгт хүрч, 2006 онтой харьцуулахад оны үнээр 37.5 хувиар, зэрэгцүүлэх үнээр 17.1 хувиар өслөө.

Мал аж ахуйн салбарт 2007 онд нядалгааны жингээр 188.2 мянган тонн мах, 465.6 мянган тонн сүү, 19.2 мянган тонн ноос, 4.9 мянган тонн ноолуур, 7.2 сая ширхэг арьс шир үйлдвэрлэлээ.

2007 онд аминдаа малтай 226.1 мянган өрх байгаагийн 171.6 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 366.2 мянган малчид ажиллаж байна.

Манай улс 2007 онд түүхэндээ хамгийн олон мал тоолуулж, малын тоо толгой нэмэгдэхийн хэрээр эдийн засагт мал аж ахуйн салбарын эзлэх байр суурь нэмэгдэж, малчдын амьдралын түвшин ч сайжирч байна. 2007 онд нийт тоолуулсан 40.3 сая толгой малын 36.2 сая нь малчин өрхийн эзэмшилд байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 211 толгой мал, үүнээс тэмээ 1, адуу 12, үхэр 12, хонь 90, ямаа 96 ногдож байна.

Нийт малчин өрхийн 60.0 гаруй хувь нь цахилгаан эх үүсвэртэй, 20.0 хувь нь нэг буюу түүнээс дээш тооны авто машинтай болсон байна. Түүнчлэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй өрхүүд банк, мал эмнэлэг, даатгалын үйлчилгээг өөрдсөө сонгож, чөлөөтэй оролцох боломжтой болсон байна.

Дотоодын үйлдвэрт 2007 онд нийт үйлдвэрлэсэн сүүний 2.0 хувьтай тэнцэх 9.5 мянган тонн сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан шингэн сүү, тараг, бяслаг, аарц, цөцгий зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэв. Мөн нийт бэлтгэсэн махны 4.7 хувьтай тэнцэх 8.9 мянган тонн махыг дотоодын үйлдвэрт үйлдвэрийн аргаар боловсруулалт хийж мах, хиам, консерв зэрэг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Нийт авсан ноосны 8.7 хувьтай тэнцэх 1.7 мянган тонн угаасан ноос, ноолуурын 31.5 хувьтай тэнцэх 1.6 мянган тонн самнасан ноолуурыг, бэлтгэсэн үхрийн ширны 25.4 хувьтай тэнцэх 104.2 мянган ширхэг, хонины арьсны 20.6 хувьтай тэнцэх 722.4 мянган ширхэг, ямааны арьсны 8.5 хувьтай тэнцэх 238.3 мянган ширхэгийг дотоодын үйлдвэрт тус тус боловсруулсан байна.

Дээрхээс үзэхэд зах зээлийн алслагдмал байдлаас шалтгаалж мах, сүүг орон нутагт үндсэндээ гар аргаар боловсруулж, харин арьс, шир, ноос, ноолуурын багахан хувийг дотоодын үйлдвэрт боловсруулж, ихэнх хэсэг нь боловсруулалт хийлгүйгээр гадаад зах зээлд гарч байна.

2007 онд бэлтгэсэн хонины ноосны 50.0 хувь буюу 9.1 мянган тонн, бэлтгэсэн ямааны ноолуурын 66.7 хувь буюу 3.3 мянган тонн бохир, угаасан болон самнасан ноолуурыг тус тус экспортод гаргасан байна. Мөн 2007 онд бэлтгэсэн нийт арьс ширний 4.0 хувь буюу 277.8 мянган ширхэг арьсыг боловсруулалт хийлгүйгээр экспортод гаргасан байна.

Эндээс харахад дотоодын үйлдвэрийн түүхий эд болох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох ноос, ноолуурийн ихэнх хувь нь эцсийн бүтээгдэхүүн бололгүйгээр гадаад зах зээлд гарч байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 172.7 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 147.1 тэрбум төгрөгт хүрч, 2006 онтой харьцуулахад оны үнээр 17.2 хувиар, зэрэгцүүлэх үнээр 3.1 хувиар өслөө.

Газар тариалангийн салбарт 2007 онд 202.7 мянган га талбайд тариалалт хийж, 114.8 мянган тонн үр тариа, 114.5 мянган тонн төмс, 76.5 мянган тонн хүнсний ногоо хураасан нь 2006 оныхоос үр тариа 17.2 хувиар буурч, төмс 5.0 хувь, хүнсний ногоо 8.6 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд нэг га-гаас дунджаар 9.4 цн үр тариа, 99.9 цн төмс хураасан нь 2006 оныхоос үр тариа 1.6 цн-ээр, төмс 1.8 цн-ээр бага байна.

Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлд дэвшил гаргахын тулд Монгол Улсын Засгийн Газраас “Монгол орны нөхцөлд газар тариалан эрхлэх технологийн шинэчилсэн зөвлөмж”-ийг 2006 онд боловсруулан гаргасан бөгөөд 2007 онд энэ шинэчлэлийг эрчимжүүлэх жил болгон ажилласны үр дүнд хэдийгээр тариалангийн бүс нутгуудаар агаарт олон хоног үргэлжилсэн нарны хэт халалт болсон зэрэг цаг агаарын байдал таагүй байсан боловч тус салбарын үйлдвэрлэлийн хэмжээ нийт дүндээ өсөлттэй гарсан юм.

Ер нь газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээр нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн уринш боловсруулалтыг нэмэгдүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, таримал ургамлын элит болон сортын үрийг үйлдвэрлэх замаар ганд тэсвэртэй хүнсний болон тэжээлийн таримлын үрийг үржүүлэх, сортын үрээр хангах, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

